



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН
2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

CONTENTS

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ.....	4
1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ.....	10
1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого	11
1.2. Нэгдсэн төсвийн зарлага.....	12
1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	14
1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал.....	15
1.5. Татварын зарлага	17
1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	18
1.7. Нэмэлт төсөв.....	25
1.8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	26
2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ	30
2.1. Улсын төсвийн орлого	30
2.2. Улсын төсвийн зарлага.....	32
2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт	41
2.4. Засгийн газрын нөөц сан.....	54
3. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН	55
4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН.....	56
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	57
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	58
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ.....	59
8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	61
8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС.....	63
8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС	64
8.3. ГАДААД ЗЭЭЛ	65
8.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА	66
8.5. ОРОН НУТГИЙН ЗЭЭЛЛЭГ	67
8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ	68

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн 39 ерөнхийлөн захирагч, нийслэл, аймаг, дүүргийн 3,718 төсөвт байгууллагууд, Үндэсний баялгийн сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно.

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2024 онд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 онд 31,456.6 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 920.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд 443.9 тэрбум, Хуримтлалын санд 500.6 тэрбум, Ирээдүйн өв санд 841.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн өсөлт. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүн 80.0 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг 4.9 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхай, түүнийг дагасан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлсөн бол хөдөө аж ахуйн салбарын бууралт өсөлтийг хязгаарлалаа.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудын оролцоогоор

	2021	2022	2023	2024*
Эдийн засгийн өсөлт	1.6	5.0	7.4	4.9
Хөдөө аж ахуй	-0.8	1.7	-1.3	-3.6
Уул уурхай	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах үйлдвэрлэл	-0.1	0.5	0.4	-0.1
Цахилгаан, хий, уур	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.9	0.2	0.1	0.3
Бөөний, жижиглэн худалдаа	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр, агуулах	-0.3	0.4	1.8	1.3
Мэдээлэл холбоо	0.5	0.2	0.5	0.5
Үйлчилгээний бусад	1.1	1.6	1.7	2.2
Цэвэр татвар	1.3	1.4	0.8	2.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо* - урьдчилсан гүйцэтгэл

Уул уурхайн салбар өмнөх оноос 10.8 хувиар өсөж, эдийн засгийн 4.9 хувийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүллээ. Тухайлбал нүүрс олборлолт 2024 онд 101.5 сая тоннд хүрч, өмнөх оноос 25 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 1.6 сая тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар, төмрийн хүдэр олборлолт 10.1 сая тоннд хүрч 32 хувиар өссөн нь тус салбарын өсөлтөд голлох нөлөөтэй байв.

Тээврийн салбарын хувьд, экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт сайн байж, тээвэр зохион байгуулалт сайжирснаар 23 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.3 нэгж хувийг бүрдүүлэв. Авто болон төмөр замаар тээсэн ачаа, мөн дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдсэн нь тус салбарын өсөлтөд голлон нөлөөллөө.


Харин цаг агаарын нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 9.4 саяд хүрч, өмнөх оноос 4.4 саяар өссөн, бойжуулсан төлийн тоо 2.1 саяар буурснаар хөдөө аж ахуйн салбар 28.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарлалаа.

Эрэлтийн талаас эдийн засгийн өсөлтөд эцсийн хэрэглээ, хөрөнгийн хуримтлалын өсөлт голлон нөлөөллөө. Засгийн газар цалин, тэтгэврийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлснээр өрхийн бодит орлогыг дэмжиж, өрхийн хэрэглээний өсөлт эдийн засгийн өсөлтөд 8.6 нэгж хувийн эерэг оролцоотой байлаа. Түүнчлэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөгжлийн мега төслүүд 2024 оноос хэрэгжиж эхэлснээр улсын төсвийн хөрөнгө оруулалт 53 хувиар нэмэгдсэний зэрэгцээ манай улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 18 орчим хувиар өссөн нь хөрөнгийн хуримтлалын өсөлтөд голлон нөлөөллөө.

Инфляц. Инфляцын түвшин 2024 оны эцэст улсын хэмжээнд 9.0 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар нэмэгдлээ. Харин жилийн дундаж инфляц 2023 онд 10.4 хувь байсан бол 2024 онд 6.8 хувь болж 3.6 нэгж хувиар буурсан байна.

Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд гадаад валютын нөөц нэмэгдэж, валютын зах зээлд ханш тогтворжих суурь нөхцөл болсны зэрэгцээ Засгийн газраас түлш, шатахуун, гол нэр төрлийн хүнсний хангамжийг сайжруулж, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт тогтворжсоноор инфляц 2024 оны эхний хагаст алгуур буурлаа.

Зураг 1. Жилийн инфляц ба инфляцын зорилт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Харин 2024 оны сүүлийн хагаст инфляц эргэн эрчимжсэн нь хүнсний болон үйлчилгээний үнийн өсөлт өндөр түвшинд хадгалагдах, цаашлаад төрийн зохицуулалттай бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна. Инфляц 2024 оны эцэст 9.0 хувьтай гарахад 2.5 нэгж хувь буюу 28.0 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн өсөлтөөс шалтгаалжээ. Түүнчлэн сургалтын төлбөр, ус, цахилгаан зэрэг төрийн зохицуулалттай бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өсөлт нь инфляцыг 1.9 нэгж хувиар нэмэгдүүлсэн нь өмнөх оны мөн үеэс даруй 4.2 дахин нэмэгдсэн үзүүлэлт боллоо.

Харин импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс 2.6 нэгж хувь буюу 29.1 хувь нь шалтгаалсан байна. Худалдааны түнш орнуудын инфляц, тээврийн зардлын өсөлт саарч гадаад худалдааны нөхцөл сайжрахын зэрэгцээ төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байсан нь импортын барааны үнийн өсөлтийг сааруулахад голлон нөлөөлжээ.

Зураг 2. Инфляцын бүтцийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Гадаад худалдаа. Монгол Улс 2024 онд 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 12.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Нийт экспорт 15.8 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 3.9 хувиар өссөн бөгөөд үүнд зэсийн баяжмал, алт, төмрийн хүдрийн экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Экспортыг эрчимжүүлэх, хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн шат дараалсан бодлогын үр дүнд Монгол Улс 2024 онд түүхэндээ хамгийн өндөр буюу 83.8 сая тонн нүүрсийг экспортолсон. Түүнчлэн Оюутолгойн гүний уурхай энэ онд ашиглалтад орсноор зэсийн баяжмалын экспорт 1.7 сая тоннд хүрч, өмнөх оноос 11.2 хувиар өссөн байна. Ингэснээр нүүрсний экспорт 2019 оны буюу цар тахлын өмнөх түвшнээс 2.3 дахин, өмнөх оноос 21 хувиар өссөн амжилттай байна.

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, хөгжлийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эхэлснээр 2024 онд нийт импорт 11.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 25.5 хувиар өссөн байна. Нийт импортын 42.7 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 18.6 хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа бөгөөд улсаар нь авч үзвэл 40.0 хувийг БНХАУ, 24.3 хувийг ОХУ, 10.1 хувийг Япон Улсаас импортолжээ.

2024 онд уул уурхай, тээвэр, боловсруулах салбарын өсөлт өндөр байснаар хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох машин механизм, тоног төхөөрөмж болон түүний сэлбэг хэрэгслийн импорт 2.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 17.1 хувиар өслөө. Түүнчлэн 2024 онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч өссөнтэй холбоотойгоор дизель түлшний импорт өмнөх оноос 11.2 хувиар өсөж 1.3 тэрбум ам.долларт хүрлээ.

Зураг 3. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, тэрбум ам.доллар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн тэнцэл. 2024 онд импортын өсөлтөөс шалтгаалан урсгал данс 2.4 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан хэдий ч санхүүгийн данс 3.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Санхүүгийн дансны орох урсгалд гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, арилжааны банк, хувийн байгууллагууд олон улсын зах зээлээс амжилттай санхүүжилт татсан нь голлон нөлөөлсөн байна. Улмаар төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн жил 4.9 тэрбум ам.доллар байсан гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5.5 тэрбум ам.долларт буюу түүхэн дээд хэмжээндээ хүрсэн байна.

Санхүүгийн дансны хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 31.8 хувиар өссөн нь орох урсгалыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлсөн. Багцын хөрөнгө оруулалтын хувьд нийслэл Улаанбаатар хот 500 сая ам.долларын бондыг, Голомт банк 400 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд амжилттай арилжсан байна.

Зураг 4. Төлбөрийн тэнцэл, гүйцэтгэл, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Ажил эрхлэлт, ажилгүйдэл

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 2024 онд ажиллах хүч 1.4 сая хүн болж, өмнөх оноос 53 мянган хүнээр (+4%) нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам 27 мянгаар буурч 869.2 (-3%) болжээ.

Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

	2021-IV	2022-IV	2023-IV	2024-IV
Ажиллах хүч	1,323	1,329	1,375	1,428
Ажиллагчид	1,212	1,261	1,322	1,353
Ажилгүй хүн	110.8	68.1	53.3	75.4
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	871.2	897.9	896.7	869.2
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	60.3	59.7	60.5	62.2
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	53.3	56.6	58.2	58.9


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажиллагчид: 2024 онд Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд нийт ажиллагсдын тоо 1,353 мянгад хүрч, өмнөх оноос 31 мянгаар буюу 2%-иар өссөн нь эдийн засгийн идэвх сэргэж, хөдөлмөр эрхлэлтийн орчин сайжирсныг илэрхийлж байна. Энэ өсөлтөд үйлчилгээний салбар голлон нөлөөлсөн бөгөөд ажиллагсдын тоо өмнөх оноос 66 мянгаар нэмэгдэж, нийт 733.9 мянгад хүрсэн нь 10%-ийн өсөлттэй үзүүлэлт юм. Үйлдвэрлэлийн салбарт мөн тогтвортой өсөлт ажиглагдсан бөгөөд ажиллагсдын тоо 3.5 мянгаар нэмэгдэн 231.2 мянгад хүрсэн байна.

Харин уламжлалт гол салбарууд болох уул уурхай, олборлолт болон хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбарт ажиллах хүчний бууралт ажиглагдлаа. Тухайлбал:


Уул уурхайн салбарт ажиллагсдын тоо 78.4 мянгаас 67.1 мянга болж, 11.3 мянгаар буурсан бол хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо 348.3 мянгаас 321.3 мянга болж, 27 мянгаар буурсан байна.

Зураг 5. Ажилчид, мянган хүн



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Зураг 6. Ажилгүйдлийн түвшин, хувиар




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Ажилгүйдлийн түвшин: 2021 оны эхэнд ажилгүйдлийн түвшин 9 хувьтай байснаас хойш тогтмол буурч, 2024 оны IV улиралд 5.3 хувьд хүрсэн байна. Нийт дүнгээр 2021 оноос хойш ажилгүйдлийн түвшин аажмаар буурсан хандлагатай байгаа бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл тогтворжиж байгааг илтгэж байна.

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 онд 31,456.6 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 443.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 841.4 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 500.6 тэрбум төгрөгийг хуваарилсан. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 29,670.8 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,591.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүн¹-ий 1.15 хувьтай тэнцэж байна.

Зураг 7. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт /2019- 2024 он, тэрбум төгрөг/



Тогтворжуулалтын сан: Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс 34.7 тэрбум төгрөгөөр дутуу буюу 443.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хуримтлалын сан: Хуримтлалын санд 2024 онд 499.5 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 500.6 тэрбум төгрөг төвлөрөн 100.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ирээдүйн өв сан: Ирээдүйн өв санд 2024 онд 789.0 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 841.4 тэрбум төгрөг төвлөрөн 106.6 хувийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус сангийн хуримтлал 3,974.5 тэрбум төгрөг байна.

¹ ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 79,956,293.3 сая төгрөг
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 29,670.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1.8 хувь буюу 553.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 6,375.9 тэрбум төгрөгөөр буюу 27.4 хувиар нэмэгдсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлт 99.6 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 95.2 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 97.8 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 95.2 хувь байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,991.1	31,456.6	98.3	-534.5
ИРЭЭДҮЙН ӨВ САН	789.0	841.4	106.6	52.4
ХУРИМТЛАЛЫН САН	499.5	500.6	100.2	1.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	478.6	443.9	92.8	-34.7
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,224.1	29,670.8	98.2	-553.3
1. Татварын орлого	27,910.7	27,417.4	98.2	-493.4
Орлогын албан татвар	8,620.7	8,970.6	104.1	349.9
ААН-ын орлогын албан татвар	6,149.1	6,419.1	104.4	269.9
Нийгмийн даатгалын орлого	5,037.3	4,731.8	93.9	-305.5
Хөрөнгийн албан татвар	455.2	459.5	100.9	4.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,220.2	5,866.8	94.3	-353.4
Онцгой албан татвар	968.0	1,107.4	114.4	139.4
Тусгай зориулалтын орлого	28.0	26.4	94.4	-1.6
Гадаад үйл ажиллагааны орлого	1,932.5	1,792.3	92.7	-140.2
Бусад татвар, төлбөр, хураамж	4,648.7	4,462.6	96.0	-186.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,149.1	4,066.7	98.0	-82.4
Газрын төлбөр	365.6	243.6	66.6	-121.9
2.Татварын бус орлого	2,313.4	2,253.5	97.4	-59.9

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 27,417.4 тэрбум төгрөгт хүрч, 98.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Орлогын албан татвар 349.9 тэрбум төгрөг төгрөгөөр, Онцгой албан татвар 139.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн ч Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 353.4 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 305.5 тэрбум төгрөгөөр, Бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 186.2 тэрбум төгрөгөөр, Гадаад үйл ажиллагааны орлого 140.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу биелсэн нь татварын орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс 493.4 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд голлон нөлөөлсөн байна.

1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 онд батлагдсанаар хөшөө дурсгал, угтах хаалга барьж байгуулах болон дэд, орлогч дарга нарын орон тоо, автомашины хэрэглээг хязгаарласан нь төсвийн сахилга хариуцлагыг чангатгах, төрийн үрэлгэн байдлын эсрэг соёл, чиг хандлагыг тогтоох эерэг үр дагавартай болсон.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 онд 30,590.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 8.9 хувь буюу 3,004.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,595.3	30,591.1	91.1	-3,004.2
А. УРСГАЛ ЗАРДАЛ	23,106.2	22,176.6	96.0	-929.6
1. Бараа, ажил үйлчилгээний зардал	10,132.1	9,556.9	94.3	-575.3
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,516.8	5,368.5	97.3	-148.3
2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	0.0
3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	557.0	498.0	89.4	-59.0
4. Хангамж, бараа материалын зардал	344.6	320.8	93.1	-23.8
5. Нормативт зардал	324.7	321.0	98.8	-3.8
6. Эд хогшил, урсгал засварын зардал	258.6	243.8	94.3	-14.7
7. Томилолт, зочны зардал	91.9	76.5	83.3	-15.4
8. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580.1	1,422.1	90.0	-158.0
9. Бараа үйлчилгээний бусад зардал	1,458.4	1,306.1	89.6	-152.3
2. Хүү	1,246.1	1,236.0	99.2	-10.1
3. Татаас	1,022.0	954.5	93.4	-67.5
4. Урсгал шилжүүлэг	10,705.9	10,429.3	97.4	-276.6
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,379.2	7,970.8	76.8	-2,408.5
1. Барилга байгууламж	6,844.3	5,355.3	78.2	-1,489.0
2. Их засвар	642.3	314.7	49.0	-327.6
3. Тоног төхөөрөмж	986.7	803.7	81.5	-183.0
4. Бусад хөрөнгө	1,895.6	1,486.6	78.4	-409.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	10.4	10.4	100.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109.9	443.7	403.8	333.8
1. Эргэж төлөгдөх зээл	-350.1	-15.2	4.3	335.0
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	460.0	458.9	99.8	-1.1

Хөрөнгийн зардал 2,408.5 тэрбум төгрөг, бараа, ажил, үйлчилгээний зардал 575.3 тэрбум төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 276.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэл 91.1 хувийн гүйцэтгэлтэй гарахад голлон нөлөөлсөн байна.

Улсын төсөв 5.8 хувь буюу 1,305.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 21.4 хувь буюу 1,981.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдэл 3,004.2 тэрбум төгрөгт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 5. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2024 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	33,595.3	30,591.1	(3,004.2)
Улсын төсөв	22,677.8	21,372.4	(1,305.4)
Орон нутгийн төсөв	9,239.7	7,258.6	(1,981.2)
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	1,848.2	1,926.9	78.7
Нийгмийн даатгалын сангийн төсөв	5,121.2	5,104.7	(16.5)

1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Хүснэгт 6. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2024 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	(3,371.2)	(920.2)	2,451.0
Улсын төсөв	(2,504.1)	(1,283.3)	1,220.8
Орон нутгийн төсөв	(1,755.8)	(136.8)	1,619.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	116.6	(5.2)	(121.8)
Нийгмийн даатгалын сангийн төсөв	772.1	505.0	(267.1)

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,283.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн тэнцэл 136.8 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 5.2 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 505.0 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 898.9 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт нийт 1,232.9 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 137.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	ЭМДС	НДС
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-920.2	-1,283.3	-136.8	-5.2	505.0
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	920.2	1,283.3	136.8	5.2	-505.0
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-10.9	862.8	-373.9	5.2	-505.0
ЗГ-ын бонд	-226.6	-736.4	509.8	0.0	0.0
Урт хугацаат	-226.6	-736.4	509.8	0.0	0.0
Дотоод	672.3	162.5	509.8	0.0	0.0
Шинээр гаргах	809.8	300.0	509.8	0.0	0.0
Үндсэн төлбөр	-137.5	-137.5	0.0	0.0	0.0
Гадаад	-898.9	-898.9	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-898.9	-898.9	0.0	0.0	0.0
ЗГ-ын зээл	1,156.7	1,156.7	0.0	0.0	0.0
Гадаад	1,156.7	1,156.7	0.0	0.0	0.0
Төслийн зээл	1,307.8	1,307.8	0.0	0.0	0.0
Шинээр авах	2,047.6	2,047.6	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-739.8	-739.8	0.0	0.0	0.0
Хөтөлбөрийн зээл	-151.1	-151.1	0.0	0.0	0.0
Шинээр авах	342.0	342.0	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-493.1	-493.1	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	1.1	0.2	0.9	0.0	0.0

1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Улсын Их Хурлаас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2024 төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг төсвийн тусгай шаардлагад бүрэн нийцүүлэн боловсруулж, батлуулсан.

Төсвийн орлогын тусгай шаардлага: Монгол Улсын 2024 оны төсвийн орлогыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн төсөлд тусгасан гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.

Төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлага: Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

	2024
Хуулийн хязгаар	2.0
Гүйцэтгэл	2.1

Урсгал зарлагын тусгай шаардлага: Нэгдсэн төсвийн урсгал зардлыг ДНБ-ний 30 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж, зарлагын өсөлтийг хүн ам зүйн статистик өөрчлөлтөөр нэмэгдэх нийгмийн суурь үйлчилгээ болон инфляц, ханшийн өөрчлөлттэй уялдаж нэмэгдэх бараа, ажил, үйлчилгээний зардалд голлон чиглүүлж, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, төрийн байгууллагуудын орон тооны давхардлыг арилгах, төрийн үйл ажиллагааг хүрэх үр дүн, гүйцэтгэлд суурилж санхүүжүүлэх бодлого баримталсан.

Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь 2024 онд 27.7 байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасан тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

	2024
Хуулийн хязгаар	30.0%
Гүйцэтгэл	27.7%

Өрийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.” гэж заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024-2026 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь

	2024
Хуулийн хязгаар	60.0%
Гүйцэтгэл	41.8%

1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг ойлгохоор, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй байхаар тус тус заасан.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,587.2 тэрбум төгрөг² буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 5.1 хувьд хүрэхээр байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 11. Татварын зарлагын хэмжээ/ тэрбум төгрөг/

Байгууллага	Татварын дүн	Татвар төлөгчийн тоо
Татварын байгууллага	1,443.1	1,049,677
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	946.5	9,530
Хувь хүний орлогын албан татвар	209.0	1,014,578.00
Нэмэгдсэн өртгийн албан татвар	287.5	21,802
Гаалийн байгууллага	143.9	1,470
Гаалийн албан татвар	38.4	547
Нэмэгдсэн өртгийн албан татвар	105.5	923
Нийт татварын зарлага	1,587.2	1,025,600

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 90.9 хувь буюу 1,443.1 тэрбум төгрөгийг татварын алба, 9.1 хувь буюу 143.9 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д /цаашид “цахим систем” гэх/ нийтэлсэн төлөвлөгөө, түүний биелэлт, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн мөн журмын 4 дэх хэсэгт заасны дагуу хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн болно.

1. Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан байдал

Тайлант хугацаанд 64 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 2,203 захиалагч худалдан авах ажиллагаа хэрэгжүүлсэн талаар мэдээлэл ирүүлээ. Үүнийг 2023 онтой харьцуулбал цахим системд тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагчийн тоо 2024 онд 357 буюу 37 хувиар нэмэгдсэн байна. Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа захиалагчийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020-2024 онуудын хооронд зарласан тендер шалгаруулалтын төсөвт өртгийн хэмжээ 5.7 их наяд төгрөгөөс 26.0 их наяд төгрөг болж, ойролцоогоор 4.5 дахин нэмэгдсэн байна.

Зураг 8. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг ба тоо /их наяд төгрөг/



2024 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртөг 2023 оноос 14,118.5 тэрбум төгрөг буюу 116 хувиар нэмэгдсэн нь Нийслэлээс зарласан “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)”, “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол”, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан “Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт”, “Тавантолгой” ХК-аас зарласан “Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил /багцтай/” зэрэг төсөл арга хэмжээний төсөвт өртөгтэй холбоотой байна. Дээрх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 11.1 их наяд

төгрөг буюу 2024 онд зохион байгуулсан нийт тендер шалгаруулалтын төсөвт өртгийн 42 хувийг эзэлж байна.

Нөгөөтээгүүр, 2024 оны нийт зарласан тендер шалгаруулалт 2023 оноос 4,071 буюу 29.8 хувиар нэмэгдсэн байна. Дээрх үзүүлэлтээс үзэхэд зохион байгуулж байгаа тендер шалгаруулалт нь төсөвт өртгийн өсөлттэй шууд хамааралгүй байна. Харин цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагчийн тоо нэмэгдсэн, бага төсөвт өртөг бүхий олон тендер шалгаруулалт зарласантай холбоотой байна.

2. Тендер шалгаруулалт зарласан байдал

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд нийт 32,028.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22,481 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөсөн байх боловч 25,981.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17,718 тендер шалгаруулалт зарласан байна. Гүйцэтгэл төсөвт өртгийн тухайд 81 хувь, тендер шалгаруулалтын тухайд 79 хувьтай байна.

Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл /их наяд төгрөг/


Он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		
	Төсөвт өртөг	Өсөлт /өмнөх оноос/	ТШ-ын тоо	Төсөвт өртөг	Өсөлт /өмнөх оноос/	ТШ-ын тоо
2023	14.8	2.8%	17,576	11.9	18.59%	13,647
2024	32.0	116.0%	22,481	26.0	119.01%	17,718

Дээрх төлөвлөгөөний төсөвт өртөг болон тоо хэмжээг 2023 онтой харьцуулахад төсөвт өртөг 116 хувиар, тоо хэмжээ 27.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2024 онд төлөвлөгөөнд тусгасан нийт төсөвт өртгийн 19 хувь буюу 6.1 их наяд төгрөг бүхий 4,700 орчим тендер шалгаруулалт зарлаагүй байна.

Зарлагдаагүй тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэрээр авч үзвэл 3.3 их наяд төгрөг буюу 54.7 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, 2.01 их наяд төгрөг буюу 33.3 хувийг орон нутгийн төсөв, 0.6 их наяд төгрөг буюу 9.9 хувийг улсын төсөв, үлдэх хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Нийт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн 11,628.7 тэрбум төгрөг буюу 43 хувийг өөрийн хөрөнгө, 8,632.1 тэрбум төгрөг буюу 33 хувийг орон нутгийн төсөв, 5,473.6 тэрбум төгрөг буюу 21 хувийг улсын төсөв, 405.2 тэрбум төгрөг буюу 2 хувийг зээл, тусламж, 202.1 тэрбум төгрөг буюу 1 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.


Зураг 9. Санхүүжилтийн эх үүсвэр



Харин 2023 онд 8,562.2 тэрбум төгрөг буюу 72 хувийг өөрийн хөрөнгө, 1,487.9 тэрбум төгрөг буюу 13 хувийг улсын төсөв, 1,401.2 тэрбум төгрөг буюу 12 хувийг орон нутгийн төсөв, 290.7 тэрбум төгрөг буюу 2 хувийг бусад, 1.5 тэрбум төгрөг буюу 1 хувийг зээл, тусламжийн эх үүсвэр эзэлж байсан байна.

Тайлант хугацаанд зарлагдсан тендерийг тендер шалгаруулалтын аргаар ангилж үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8,531 буюу 48.16 хувь, харьцуулалтын аргаар 8,256 буюу 46.58 хувь, гэрээ шууд байгуулах аргаар 907 буюу 5.12 хувь, нэг эх үүсвэрийн аргаар 20 буюу 0.13 хувь, ерөнхий гэрээний аргаар 3 тендер шалгаруулалт зохион байгуулагдсан байна. Нийт тендер шалгаруулалтын 95 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын арга болон харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан байна.

Зураг 10. Зохион байгуулсан тендер шалгаруулалтын арга, тоо



Нээлттэй тендер шалгаруулалтын арга болон харьцуулалтын аргын дагуу зохион байгуулсан тендер шалгаруулалтыг төсөвт өртөг болон тоо хэмжээгээр авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлагдсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 25.2 их наяд төгрөг буюу 97.3 хувь, харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 0.5 их наяд төгрөг буюу 2 хувь, бусад арга 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Үүнээс үзэхэд төрийн худалдан авах ажиллагааны 95 хувь нь ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг хангасан байдлаар зохион байгуулагдсан байна.


3. Тендер шалгаруулалт зарлагдсан байдал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж, мөн Сангийн сайдын 2023 оны А/250 тоот тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11-д “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах...” гэж заасан байдаг.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2024 онд 22,481 тендер шалгаруулалт зохион байгуулахаар тусгаж, 17,718 тендер шалгаруулалт зарласан. Төлөвлөлт болон хэрэгжилтийг хугацааны хувьд харьцуулж үзвэл нийт тендер шалгаруулалтын 22 хувийг 1 дүгээр сард, 23 хувийг 2 дугаар сард, 16 хувийг 3 дугаар сард зарлахаар төлөвлөсөн боловч 1 дүгээр сард 5 хувийг, 2 болон 3 дугаар сард тус тус 14 хувийг зарласан буюу захиалагч нар тендер шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаандаа зарлахгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа хойшлох нэг шалтгаан болж байна.

Тендер шалгаруулалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг үзэхэд төлөвлөгөөгөөр захиалагч нар тендер шалгаруулалтыг 1, 2 дугаар саруудад эхлүүлэхээр төлөвлөж баталсан байх боловч хэрэгжилтийг авч үзвэл тендер шалгаруулалтыг 3, 4, 5, 6 саруудад эхлүүлсэн байгаа нь батлагдсан төлөвлөгөөг мөрдөж ажилладаггүй бөгөөд төсвийн жил дундаа орсон байхад тендер шалгаруулалт зарлаж эхэлдэг байна.

Дээрх хандлага орон нутаг, яамд, нийслэл, төрийн өмчит компанийн хувьд ижил байгаа бөгөөд жилийн 6-12 дугаар сард төлөвлөснөөс олон тооны тендер шалгаруулалтыг зарласан байна.




Зураг 11. Зарлахаар төлөвлөсөн болон зарласан тендер шалгаруулалтын тоо

2024 онд 17,718 тендер шалгаруулалт зохион байгуулахад цахим системд 30,698 удаа зарлал нийтлэгдсэн. Цахим системд нийтлэгдсэн зарлалаас үзэхэд нийт зарлалын 20,348 буюу 66 хувь нь оролцогчтой, 10,350 буюу 34 хувь нь оролцогчгүй байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад оролцогчгүй зарлалын тоо 10 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хуульд зааснаар тендер шалгаруулалтад нэг ч оролцогч тендер ирүүлээгүй, эсвэл ирүүлсэн тендерүүд захиалагчийн тогтоосон шаардлага хангахгүй тохиолдолд бүх тендер шалгаруулалтаас татгалзаж тухайн тендер шалгаруулалтыг дахин зарлах нөхцөл үүсдэг. Ийнхүү дахин зарласан тохиолдолд төсөл, арга хэмжээний эхлэх хугацаа хойшилж, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжгүй болдог.


Зураг 12. Дахин зарласан тендер шалгаруулалтын тоо



Дахин зарласан тендер шалгаруулалтын тоо 2024 онд 31.6%-аар нэмэгдсэн бөгөөд 2023 онтой харьцуулахад дахин зарлах байдал буураагүй бөгөөд 1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд тендер шалгаруулалт зарласан хугацаанаас захиалагчийн шийдвэр гарах хүртэл дундаж хугацаа 2023 онд **34.1** өдөр байсан бол 2024 онд **28.4** өдөр болж буурсан байна.

Зураг 13. Тендер зарласан өдрөөс захиалагч шийдвэр гаргах хугацаа /хоног/



4. Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдлын шийдвэрлэгдсэн байдал

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар Сангийн яам захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хүлээн авч, ажлын 10 хоногт хянан шийдвэрлэдэг.

Тайлант хугацаанд 1544 тендер шалгаруулалттай холбогдуулан 1066 оролцогчоос гаргасан 2176 гомдлыг хянан шийдвэрлэсэн нь 2023 оноос 31.7%-аар өссөн үзүүлэлттэй байна. Дараах хүснэгтэд оролцогч нараас Сангийн яаманд ирүүлсэн гомдлын талаарх мэдээллийг 2022-2024 оны байдлаар харуулав.

Хүснэгт 13. Санхүүжилтийн эх үүсвэр

Он	Нийт тендер шалгаруулалт	Гомдол гарсан тендер шалгаруулалт	Нийт ТШ-д гомдлын эзлэх хувь	Гомдол гаргасан оролцогч	Ирүүлсэн гомдол (давхардсан тоогоор)	Гомдлын үндэслэлтэй хувь
2022 он	12576	734	6%	548	968	82.0%
2023 он	13647	994	7%	811	1487	73.6%
2024 он	17718	1544	9%	1066	2176	80.6%

Нийт тендер шалгаруулалтын тоо 2023 онд 13,647 буюу 8.5 хувиар, 2024 онд 17,718 буюу 29.8 хувиар тус тус нэмэгдсэн бол гомдол гарсан тендер шалгаруулалт 2023 онд 260 буюу 35.5 хувиар, 2024 онд 550 буюу 55.3 хувиар тус тус өссөн байна. Харин нийт тендер шалгаруулалтад гомдол гарсан тендер шалгаруулалтын хувь 2023 онд 7 хувь, 2024 онд 9 хувь болсон байна.

Үүнээс үзэхэд нийт тендер шалгаруулалтын тооны өсөлттэй харьцуулахад гомдол гарч буй тендер шалгаруулалтын өсөлтийн хувь илүү байгаа нь шалгараагүй оролцогч нар захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй байх хандлага өссөн ажиглагдаж байна.

1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан нэмэлт төсвийг 2024 онд бүрдүүлэн холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн нийт эх үүсвэр 2024 онд 1,160.1 тэрбум төгрөг төвлөрөн, 844.5 тэрбум төгрөг буюу 72.8 хувийг төсвийн эх үүсвэрээс, 315.6 тэрбум төгрөг буюу 27.2 хувийг төсвийн бус эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 482.9 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 56.5 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 259.1 тэрбум төгрөг;
- Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 354.5 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 7.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд нэмэлт төсвөөр 1,160.5 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан байна.

Нийт зарлагын гүйцэтгэлийг сайдын багцуудаар авч үзвэл:

Нийслэл Улаанбаатар хот 199.5 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайд 132.1 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 105.1 тэрбум төгрөг, Монгол Улсын Шадар сайд 87.7 тэрбум төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн сайд 73.2 тэрбум төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 63.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт зарцуулалтад голлон нөлөөлсөн байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь түүвэрлэн авч үзвэл:

Бараа үйлчилгээний бусад зардал 361.3 тэрбум төгрөг 31.1 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 219.7 тэрбум төгрөг 18.9 хувийг, хөрөнгийн зардал 67.5 тэрбум төгрөг 5.8 хувийг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 60.5 тэрбум төгрөг 5.2 хувийг, томилолтын зардал 53.0 тэрбум төгрөг 4.6 хувийг тус тус эзэлж байна.

1.8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланг тайлагнах эрх зүйн актыг 2023 оны 12 дугаар сард Сангийн сайдын 225 тоот тушаалаар батлуулсан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж улсын хэмжээнд батлагдсан төсвийг үр дүнтэй уялдуулан үр ашгаа тайлагнадаг онцлогтой. Монгол Улсын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн”-ийн тайланд улсын төсвийн 39, орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн тайланг холбогдох журмын дагуу нэгтгэсэн³. Үүнд нийт 7944 хөтөлбөрийн үр дүнг нэгтгэсэн бөгөөд үүнээс 104 хөтөлбөрийн 124 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 399 хөтөлбөрийн 461 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 135 хөтөлбөрийн 209 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй буюу нийт батлагдсан хөтөлбөрийн 84 хувь нь буюу 534 хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.

Хүснэгт 14. Монгол Улсын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт (улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч багтсан байдлаар)

Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100 %-иас дээш	135	209	365	91%	136%	145%	57%
85 %-100 %	399	461	554	89%	96%	97%	15%
85 %-иас бага	104	124	203	78%	65%	50%	-18%
НИЙТ	638	794	1122				
Үүнээс: Улсын төсөв							
Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100 %-иас дээш	51	107	233	92%	155%	162%	72%
85 %-100 %	36	83	121	88%	94%	95%	6%
85 %-иас бага	17	25	58	83%	59%	50%	-32%
НИЙТ	104	215	412				
Орон нутгийн төсөв							

³ Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаал. “Маягт аргачлал батлах тухай”

⁴ Давхардсан тоогоор

Хөтөлбөрийн гүйцэтгэлийн ангилал	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
100 %-иас дээш	84	102	132	90%	117%	127%	42%
85 %-100 %	363	378	433	90%	98%	98%	24%
85 %-иас бага	87	99	145	73%	72%	49%	-4%
НИЙТ	534	579	710				

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, шалгуур үзүүлэлт:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт буюу “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”⁵-ээр 39 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 104 хөтөлбөр, 215 хөтөлбөрийн үр дүнд нийт 412 хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тайлант хугацаанд 17 хөтөлбөрийн 25 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 36 хөтөлбөрийн 83 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 51 хөтөлбөрийн 107 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 15. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт

100%-иас дээш гүйцэтгэлтэй	Хөтөлбөр	51
	Хүрэх үр дүн	107
	Шалгуур үзүүлэлт	233
85%-100% гүйцэтгэлтэй	Хөтөлбөр	36
	Хүрэх үр дүн	83
	Шалгуур үзүүлэлт	121
85%-иас бага гүйцэтгэлтэй	Хөтөлбөр	17
	Хүрэх үр дүн	25
	Шалгуур үзүүлэлт	58

Хөтөлбөр: Улсын төсвийн 39 ерөнхийлөн захирагчийн нийт 104 хөтөлбөр батлагдсанаас давхардаагүй тоогоор 97 хөтөлбөрт хуваарилагдсан байна. Үүнээс нийт 21 төсвийн ерөнхийлөн захирагч буюу 54 хувь нь нэг хөтөлбөртэй бол хамгийн олон хөтөлбөртэй төсвийн ерөнхийлөн захирагч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд 12 хөтөлбөртэй байна.

⁵ Монгол улсын төсвийн 2024 оны төсвийн тухай хууль. Нэгдүгээр хавсралт. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл: Монгол Улсын 2024 оны батлагдсан төсвийн дагуу улсын төсвийн нийт 39 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 22.7 их наяд төгрөг батлагдсан бөгөөд жилийн эцэст 21.4 их наяд төгрөг буюу 94 хувь нь зарцуулагдсан.

Ажил байр	Төсөв (Хүн)	Төсөв (%)	Гүйцэтгэл (Хүн)	Гүйцэтгэл (%)	Гүйцэтгэлийн хувь (%)
АВЛИГАТАЙ...	~100	~0.5%	~100	~0.5%	95%
АЖ ҮЙЛДВЭР...	~100	~0.5%	~100	~0.5%	95%
БАЙГАЛЬ ОРЧИН...	~200	~1%	~200	~1%	90%
БАРИЛГА ХОТ...	~400	~2%	~400	~2%	93%
БАТЛАН...	~600	~3%	~600	~3%	82%
БОЛОВСРОЛ...	~4,200	~21%	~4,200	~21%	95%
ГАДААД...	~200	~1%	~200	~1%	82%
ГЭР БҮЛ...	~4,200	~21%	~4,200	~21%	95%
ЕРӨНХИЙЛӨГЧИ...	~800	~4%	~800	~4%	95%
ЗАМ ТЭЭВРИЙН...	~100	~0.5%	~100	~0.5%	95%
ЗАСГИЙН...	~200	~1%	~200	~1%	46%
МОНГОЛ УЛСЫН...	~4,800	~24%	~4,800	~24%	87%
МОНГОЛ УЛСЫН...	~400	~2%	~400	~2%	90%
МОНГОЛ УЛСЫН...	~100	~0.5%	~100	~0.5%	94%
МОНГОЛ УЛСЫН...	~400	~2%	~400	~2%	76%
МОНГОЛ УЛСЫН...	~100	~0.5%	~100	~0.5%	91%
МОНГОЛ УЛСЫН...	~400	~2%	~400	~2%	71%
МОНГОЛ УЛСЫН...	~4,800	~24%	~4,800	~24%	99%
САНГИЙН САЙД...	~4,800	~24%	~4,800	~24%	89%
САНХҮҮГИЙН...	~400	~2%	~400	~2%	96%
СОЁЛ СПОРТ...	~600	~3%	~600	~3%	79%
СОНГУУЛИЙН...	~400	~2%	~400	~2%	87%
ТӨРИЙН...	~400	~2%	~400	~2%	94%
УЛСЫН ДЭЭД...	~400	~2%	~400	~2%	88%
УЛСЫН...	~100	~0.5%	~100	~0.5%	85%
УЛСЫН ИХ ХУРАЛ...	~400	~2%	~400	~2%	92%
ҮНДЭСН...	~4,800	~24%	~4,800	~24%	85%
ҮНДЭСНИЙ...	~4,800	~24%	~4,800	~24%	90%
ХУУЛЬ ЗҮЙН САЙД...	~1,400	~7%	~1,400	~7%	90%
ХҮНИЙ ЭРХИЙН...	~1,400	~7%	~1,400	~7%	100%
ХУНС, ХӨДӨӨ...	~600	~3%	~600	~3%	85%
ЦАГААТ АХ...	~100	~0.5%	~100	~0.5%	100%
ЦАХИМ...	~100	~0.5%	~100	~0.5%	79%
ШАДАР САЙД...	~100	~0.5%	~100	~0.5%	95%
ШҮҮХИЙН...	~100	~0.5%	~100	~0.5%	95%
ШҮҮХИЙН...	~1,600	~8%	~1,600	~8%	95%
ЭРҮҮЛ...	~400	~2%	~400	~2%	95%
ЭРЧИМ ХҮЧНИЙ...	~100	~0.5%	~100	~0.5%	95%

⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт: Улсын төсвийн нийт 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 412 шалгуур үзүүлэлт батлагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 3 шалгуур үзүүлэлттэй ба 10 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлттэй 12 төсвийн ерөнхийлөн захирагч байна. Шалгуур үзүүлэлтийн тоо хөтөлбөр болон хүрэх үр дүнгийн тоо болон төсвийн хэмжээтэй хамааралтай. Хамгийн олон үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй төсвийн ерөнхийлөн захирагч нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд
2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
3. Боловсролын сайд байна.

Нийт 412 шалгуур үзүүлэлтийн 139 нь буюу 34 хувь нь чанарын, 273 нь тоон шалгуур үзүүлэлт батлагдсан байна. Харин нийт шалгуур үзүүлэлтийн 98 хувь буюу 404 нь өсөх хандлагатай төлөвлөгдсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг SMART шинж чанараар үнэлгээ өгөх нь хүндрэлтэй юм. Бүх үзүүлэлт юуг, хэрхэн хэмжих нь тодорхой, мөн тухайн хөтөлбөрт улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжилт батлагдсан нь шалгуур үзүүлэлтийг биелэгдэхүйц болгож байна. Хөтөлбөр, үр дүн нь улсын төсөвт баталж байгаа нь тухайн хөтөлбөр болон шалгуур үзүүлэлтийг ач холбогдолтой болгож байна. Иймд цаашид анхаарах шаардлагатай байдлаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт түгээмэл гарч байгаа зарим асуудлыг доор дурдав.

2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 20,089.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 21,372.4 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 1,283.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 20,089.1 тэрбум төгрөгт хүрч, 99.6 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 84.6 тэрбум төгрөг дутуу, өмнөх оны гүйцэтгэлээс 4,004.0 тэрбум төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,652.3	20,533.0	99.4	-119.2
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	0.0	0.0	0.0
ХУРИМТЛАЛЫН САН	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	478.6	443.9	92.8	-34.7
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,173.7	20,089.1	99.6	-84.6
1. Татварын орлого	16,918.0	17,033.1	100.7	115.2
Орлогын албан татвар	3,781.4	4,307.6	113.9	526.2
<i>ААН-ын орлогын албан татвар</i>	3,781.4	4,307.6	113.9	526.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,220.2	5,866.8	94.3	-353.4
Онцгой албан татвар	968.0	1,107.4	114.4	139.4
Тусгай зориулалтын орлого	28.0	26.4	94.4	-1.6
Гадаад үйл ажиллагааны орлого	1,932.5	1,792.3	92.7	-140.2
Бусад татвар, төлбөр, хураамж	3,987.9	3,932.6	98.6	-55.3
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,630.2	3,536.8	97.4	-93.4
2.Татварын бус орлого	3,255.8	3,056.0	93.9	-199.8
Нийтлэг татварын бус орлого	1,098.4	1,178.6	107.3	80.2
<i>Хувьцааны ногдол ашиг</i>	562.1	461.6	82.1	-100.5
<i>Газрын тосны орлого</i>	1,595.3	1,415.9	88.8	-179.4
Тусламжийн орлого	20,652.3	20,533.0	99.4	-119.2
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0

Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2024 онд 20,533.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 0.6 хувиар буюу 119.2 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,355.7 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар нэмэгдсэн байна.

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 84.8 хувь татварын орлогоос, 15.2 хувь нь татварын бус орлогоос бүрдсэн байна.

Төсвийн орлогын чиглэлээр 2024 онд эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, уул уурхайн биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүллээ.

Энэ хүрээнд эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлт үргэлжилснээр, нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд буюу 83.8 сая тоннд хүрсэн. Энэхүү үзүүлэлт нь аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшинд эерэг нөлөө үзүүлж, улмаар төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого батлагдсан дүнгээс 526.2 тэрбум төгрөгөөр давж биелэхэд нөлөөлсөн байна.

Харин уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ олон улсын зах зээл дээр буурсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг батлагдсан дүнгээс 93.4 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд нөлөөлсөн байна. Тухайлбал, зэсийн үнийг 2024 онд тонн тутамд 9,500 ам долларт байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 9,099.7 ам долларт мөн нүүрсний дундаж үнийг 115.0 ам долларт байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 104.0 ам долларт тус тус хүрсэн байна.

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, татварын бүртгэл, тайлангийн статистик мэдээлэлд үндэслэн 2024 оны төсөвт дотоодын барааны НӨАТ-ын орлогыг 2,419.0 тэрбум төгрөгөөр тооцоолж төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурлаас төсвийн төслийг хэлэлцүүлэх явцад УИХ-ын Ажлын хэсэг төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой төсвийн орлого нэмэгдүүлэх санал гаргаж, улмаар улсын төсөвт хуримтлагдсан өр төлбөрийн 20 хувийг буюу 194.3 тэрбум төгрөгийг барагдуулахаар нэмэгдүүлэн баталсан. Энэ хүрээнд дотоодын барааны НӨАТ-ын орлого 2024 онд 2,524.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төлөвлөгөөний 96.0 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Харин импортын гаалийн албан татварын гүйцэтгэл 2024 онд 1,794.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 140.1 тэрбум төгрөгөөр, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 3,952.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 108.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн нь нийт импортын хэмжээ төлөвлөгөөнөөс 176 сая ам.доллараар дутуу биелсэнтэй холбоотой байна.

Онцгой албан татвартай барааны хувьд 2024 оны гүйцэтгэлээр 10,693.1 тэрбум төгрөгийн бараа импортолсон бол өнгөрсөн оны мөн үеэс 28.0%-аар буюу 2,364 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт татвартай импортод онцгой албан татвартай бараа нь 2023 онд 27.9% эзэлж байсан бол 2024 онд 29.0%-ийг эзэлж өнгөрсөн оны мөн үеэс 1.1 хувиар өссөн байгаа нь суудлын автомашины импорт өссөнтэй холбоотой байна. Тухайлбал, онцгой албан татвартай суудлын автомашин 2024 онд 122,761 ширхэг импортолсныгөмнөх оны мөн үетэй нь харьцуулахад 49,588 ширхэг буюу 67.8 хувиар өссөн нь тус орлогыг 139.4 тэрбум төгрөгөөр давж биелэхэд голлон нөлөөлсөн байна.

Татварын бус орлогын хувьд тайлант онд 199.8 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд газрын тосны орлого 47.1 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 59.9 тэрбум төгрөгөөр, гадаад тусламжийн орлого 100.6 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 179.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн, төсөвт байгууллагын өөрийн орлого 100.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс илүү төвлөрсөнтэй холбоотой байна. Тухайлбал, 2024 онд газрын тосны экспортын биет хэмжээг 4,210.0 мянган баррель гэж төлөвлөсөн ч гүйцэтгээл 135.9 мянган баррелаар бага буюу 4,074.1 мянган баррельд хүрсэн байна.

2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2024 онд 21,372.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 1,305.4 тэрбум төгрөг буюу 5.8 хувиар бага гарсан байна.

Улсын төсвийн урсгал зардалд 15,964.9 тэрбум, хөрөнгийн зардалд 5,082.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 17. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,677.8	21,372.4	94.2	-1,305.4
НИЙТ ЗАРЛАГА	22,574.7	21,047.0	93.2	-1,527.7
УРСГАЛ ЗАРДАЛ	16,475.0	15,964.9	96.9	-510.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,057.8	7,781.5	96.6	-276.2
ХҮҮ	1,173.6	1,165.9	99.3	-7.7
ТАТААС	1,841.1	1,776.1	96.5	-65.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,402.6	5,241.4	97.0	-161.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,099.7	5,082.1	83.3	-1,017.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	103.1	325.4	315.5	222.2

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 1,175.0 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 368.0 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 483.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Гадаад зээлийн үйлчилгээний зардалд 1,158.4 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний зардалд 7.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 18. Бараа, ажил үйлчилгээний зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,057.8	7,781.5	96.6	(276.2)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,839.7	4,739.4	97.9	(100.3)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	481.1	468.6	97.4	(12.6)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141.0	126.8	90.0	(14.1)
Хангамж, бараа материалын зардал	100.0	95.8	95.8	(4.2)
Нормативт зардал	316.0	313.5	99.2	(2.5)
Эд хогшил, урсгал засварын зардал	150.6	144.4	95.9	(6.2)
Томилолт, зочны зардал	73.3	60.3	82.2	(13.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,088.8	1,010.5	92.8	(78.4)
Бараа үйлчилгээний бусад зардал	867.3	822.4	94.8	(44.8)

Улсын төсвөөс олгох татаасаар 1,776.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 65.0 тэрбум төгрөгөөр дутуу буюу 96.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 19. Татаас /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
ТАТААС	1,841.1	1,776.1	96.5	(65.0)
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,440.5	1,440.4	100.0	(0.0)
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	400.6	335.6	83.8	(65.0)

Урсгал шилжүүлгийн зардалд 5,241.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 161.1 тэрбум төгрөгөөр дутуу буюу 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 20. Урсгал шилжүүлгийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,402.6	5,241.4	97.0	(161.2)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,213.5	2,179.3	98.5	(34.3)
Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,202.7	2,172.0	98.6	(30.7)
Засгийн газрын гадаад шилжүүлэг	10.8	7.3	67.4	(3.5)
Бусад урсгал шилжүүлэг	3,189.0	3,062.1	96.0	(126.9)
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34.8	34.8	100.0	-
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,350.5	2,299.0	97.8	(51.5)
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11.8	10.6	90.1	(1.2)
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	367.4	322.2	87.7	(45.2)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	200.3	181.0	90.3	(19.4)
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	199.8	190.9	95.5	(9.0)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24.3	23.7	97.3	(0.7)

Улсын төсвийн зарлагыг салбараар нь авч үзвэл:

Боловсрол:

Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хүрээнд:

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт – Боловсролын салбарын хэмжээнд 2022 оноос эхлэн хэрэгжсэн хүүхдийн тооноос хамаарсан гүйцэтгэлийн санхүүжилт нь багш, захиргаа аж ахуйн ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал, цэцэрлэгийн үйл ажиллагааны урсгал болон ариутгал, цэвэрлэгээний зардал, хүүхэд хамгааллын зардал, багшийн хөгжлийн зардал, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал, хүүхдийн тоглоом, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал гэсэн 8 чиглэлээр сургалтын байгууллагад олгогдож байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн байгууллагуудын албан хаагчдын цалингийн сан, ажил олгогчоос

- нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 764.1 тэрбум төгрөг, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 56.1 тэрбум төгрөг;
- Цэцэрлэгийн хүүхдийн хоол - Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан тарифын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуу) төгрөг”-өөр тооцож, төрийн өмчийн цэцэрлэгт суралцаж байгаа 2-5 насны 242,109 хүүхдэд 82.4 тэрбум төгрөг;
 - Төрийн бус өмчийн СӨБ, ЕБС-н хувьсах зардал – Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.5.1-т “холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасны дагуу төрийн бус өмчийн 405 цэцэрлэгт хамрагдаж байгаа 32,127 хүүхдэд 61.5 тэрбум төгрөг;

Ерөнхий боловсролын хөтөлбөрийн хүрээнд:

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт – Боловсролын салбарын хэмжээнд 2022 оноос эхлэн хэрэгжсэн хүүхдийн тооноос хамаарсан гүйцэтгэлийн санхүүжилт нь багш, захиргаа аж ахуйн ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэл, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, цахим хэрэглээ, багшийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал, сургалтын хэрэглэгдэхүүн гэсэн 7 чиглэлээр сургалтын байгууллагад олгогдож байна. Төрийн өмчийн 695 ерөнхий боловсролын сургуулиудын 52,129 (32,223 багш, 19,906 бусад) албан хаагчдын цалингийн сан, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,402.3 тэрбум төгрөг, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 72.8 тэрбум төгрөг;
- Дотуур байрны үйлчилгээ – Ерөнхий боловсролын сургуулиудын 526 дотуур байранд 36,029 хүүхдэд дотуур байрны хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардалд 85.1 тэрбум төгрөг, Засгийн газрын 2022 оны 498 дугаар тогтоолоор батлагдсан нормативын дагуу “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 (дөрвөн мянга гурван зуу) төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4000 (дөрвөн мянга) төгрөг”-өөр тооцож, дотуур байрны хоолны зардалд 34.3 тэрбум төгрөг;
- Үдийн цай хөтөлбөр –Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан тарифын дагуу нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 1,500.0 төгрөгөөр, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан тарифын дагуу ерөнхий боловсролын тусгай сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2,400.0

- төгрөгөөр тооцож, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж буй 1-5 дугаар ангийн нийт 346,287 хүүхдэд 72.9 тэрбум төгрөг;
- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилт – Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн олгох урамшуулалд 1 дүгээр түвшинд үнэлэгдсэн 1,866 багшид албан тушаалын сарын цалингийн 40 хувь, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн 5,440 багшид албан тушаалын сарын цалингийн 25 хувь, 3 дугаар түвшинд үнэлэгдсэн 4,562 багшид албан тушаалын сарын цалингийн 20 хувь, 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн 4,374 багшид албан тушаалын сарын цалингийн 15 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулалд нийт 16,242 багшид 51.0 тэрбум төгрөг;
 - Төрийн бус өмчийн СӨБ, ЕБС-н хувьсах зардал – Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүр”-ийн дагуу “Төлбөргүй болон 1,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй” 14 сургуульд 4.9 тэрбум төгрөг, “1,000,001.0-5,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй” 64 сургуульд 9.6 тэрбум төгрөг, “5,000,001.0-10,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй” 77 сургуульд 24.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Төрийн бус өмчийн 155 сургалтын байгууллагын 70,657 суралцагчид 39.3 тэрбум төгрөг;

Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд:

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт – Боловсролын салбарын хэмжээнд 2022 оноос эхлэн хэрэгжсэн хүүхдийн тооноос хамаарсан гүйцэтгэлийн санхүүжилт нь багш, захиргаа аж ахуйн ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэл, сургалтын хэрэглэгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, дадлага ажлын материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл гэсэн чиглэлээр сургалтын байгууллагад олгогдож байна. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудын албан хаагчдын цалингийн сан, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 94.2 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 11,466 суралцагчдын хувьсах зардалд 14.3 тэрбум төгрөг, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 6.0 тэрбум төгрөг;
- МСҮТ-д суралцагсдад сар тутам олгох тэтгэлэг - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 421 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2024 онд төгссөн 14,282 төгсөгчид 43.4 тэрбум төгрөг;

Дээд боловсролын хөтөлбөрийн хүрээнд:

- Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг - Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг 2021 оноос эхлэн дотоодын их, дээд сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцуулсан бөгөөд гадаадын их, дээд сургуульд 2022 оноос эхлэн суралцуулсан. Гадаадын дээд гадаадын их, дээд сургуульд суралцаж буй 723 суралцагчдад нийт 38.3 тэрбум төгрөг, дотоодын их, дээд сургуулийн бэлтгэл хөтөлбөрт 315 суралцагчдад 1.1 тэрбум төгрөг, нийт 1038 суралцагчдад 39.4 тэрбум төгрөг;

- Зарим суралцагч (нэн ядуу, малчин, 3 суралцагч)-дад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг - Давхардсан тоогоор 412 боловсролын байгууллагын 5,785 зорилтот бүлгийн суралцагчдад 12.8 тэрбум төгрөгийн тусламж олгосон байна.
- Гадаадад суралцагсдын зээл - Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/04, А/71 дугаар тушаалаар дэлхийн шилдэг их дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт гадаад зээлийн санхүүжилтээр 149 суралцагчид 12.0 тэрбум төгрөг;
- Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг - Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг 52 суралцагчид 4.9 тэрбум төгрөг;

Нийгмийн бүлэгт чиглэсэн:

Хүүхдэд чиглэсэн бодлогын хүрээнд:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,340,971 хүүхдэд 1,540.0 тэрбум төгрөг;
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны 16,883 хүүхдэд 70.1 тэрбум төгрөг;
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр 43,613 хүүхдэд 4.5 тэрбум төгрөг;
- Цаатан иргэний тэтгэмжийг 155 хүүхдэд 286.4 сая төгрөг;

Эхчүүдэд чиглэсэн бодлогын хүрээнд:

- 0-3 хүртэлх насны хүүхэд асаргааны тэтгэмж 172,109 иргэнд 73.2 тэрбум төгрөг;
- Эхийн алдар одонгийн мөнгөн тусламжийг 259,746 эхчүүдэд 32.0 тэрбум төгрөг;
- Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 8,812 иргэнд 20.0 тэрбум төгрөг;
- Жирэмсэн эхийн тэтгэмжийг 67,205 иргэнд 8.9 тэрбум төгрөг;
- Ихэр хүүхдийн тэтгэмжийг 682 эх, эцгүүдэд 1.4 тэрбум төгрөг;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлогын хүрээнд:

- 30 ТЕЗ-дын 2,417 төсвийн байгууллагад 7,830 албан хаагчдад нийт 150.3 тэрбум төгрөгийн цалин, урамшуулал;
- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн 36,623 иргэнд 142.5 тэрбум төгрөг;
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, том хүн асарч байгаа 32,230 иргэнд 94.5 тэрбум төгрөг;
- Орон сууцны хөлс, түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа үзүүлэх хөнгөлөлтийг 26,840 иргэнд 3.7 тэрбум төгрөг;
- Дотоодод хийлгэсэн протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 6,923 иргэнд 2.3 тэрбум төгрөг;
- Цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлын хөнгөлөлтийг 6,702 иргэнд 1.3 тэрбум төгрөг;

Ахмадуудад чиглэсэн бодлогын хүрээнд:

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 43,035 иргэнд 116.2 тэрбум төгрөг;
- НДС-аас өндөр настны тэтгэвэр авах эрх үүсээгүй 7,362 ахмадуудад 29.4 тэрбум төгрөг;
- Насны хишиг тэтгэмжийг 65-аас дээш насны 191,275 иргэнд 28.3 тэрбум төгрөг;
- Амралт, сувиллын газрын эрхийн бичгийн үнийн хөнгөлөлтийг 61,127 иргэнд 14.8 тэрбум төгрөг;
- Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг 47,279 иргэнд 9.2 тэрбум төгрөг;
- Байнгын асаргаа шаардлагатай 40,640 ахмад настанд 7.5 тэрбум төгрөг;

Хүнс, хөдөө аж ахуй:

Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага:

- ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал:
 - ✓ Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтөд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолын дагуу арилжааны 9 банкаар дамжуулан 2023 онд 1,634 зээлдэгч, 2024 онд 1,156 зээлдэгчид 120.9 тэрбум төгрөг;
 - ✓ Малчны зээл хойшлуулах арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2024 оны 106 дугаар тогтоолын дагуу 108,871 малчинд 74.7 тэрбум төгрөг;
 - ✓ Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтөд Засгийн газрын 2021 оны 42, 59, 131, 216 дугаар тогтоолуудын дагуу ноолуур, ноос, арьс шир, хаврын тариалалт, махны нөөц, малчдыг дэмжих хүрээнд 2021 онд 178 зээлдэгч, 2022 онд 43 зээлдэгчид 6.1 тэрбум төгрөг;

Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:

- Улаан буудайн урамшуулал – 262.0 мянган тонн хүнсний улаан буудай тариалсан 12 аймгийн 643 тариалан эрхлэгчдэд 20.4 тэрбум төгрөг;
- ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал– Хүнсний ногооны урамшуулалд 211.3 мянган тонн хүнсний ногоо зах зээлд борлуулсан 2,071 тариалан эрхлэгчдэд 20.3 тэрбум төгрөг;

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:

- Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх – Мал, амьтны гоц 4 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймаг, сумын мал эмнэлгийн нэгжүүдээр дамжуулан нийт 46,2 толгой мал хамруулан 44.5 тэрбум төгрөг;

Шинэ хоршоо хөдөлгөөн хөтөлбөрийн хүрээнд:

- Зээлийн хүүгийн татаас:
 - ✓ Хоршооны гишүүн малчинд олгосон зээлд Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын дагуу 2024 онд 5,785 хоршооны 20,324 малчинд 25.1 тэрбум төгрөг;
 - ✓ Цагаан алт хөтөлбөрийн зээлд Монгол Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолын дагуу 2024 онд 46 зээлдэгчид 18.5 тэрбум төгрөг;

Улсын төсвийн хөрөнгийн зардлын нийт зарлага 2024 онд 5,082.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 16.7 хувь буюу 1,017.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 21. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,099.7	5,082.1	83.3	(1,017.6)
Барилга байгууламж	5,015.6	4,101.3	81.8	(914.3)
Их засвар	84.5	77.6	91.8	(6.9)
Тоног төхөөрөмж	760.2	681.3	89.6	(79.0)
Бусад хөрөнгө	229.0	211.5	92.4	(17.4)
Стратегийн нөөц хөрөнгө	10.4	10.4	100.0	(0.0)

Гадаад зээл, тусламжаар нийт 136 төсөл, арга хэмжээнд 2,767.0 тэрбум төгрөг батлагдсанаас 2,506.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 90 хувьтай гарсан байна. Үүнээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих 100 төслийн зээлийн ашиглалтад 2,209.0 тэрбум төгрөг батлагдсанаас 2,068.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 94 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Харин 36 тусламжийн төсөл, арга хэмжээний ашиглалтад 558.0 тэрбум төгрөг батлагдсанаас 437.9 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, гүйцэтгэл 78 хувьтай байна.

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ - 2024

ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДҮН	НИЙТ	2024 ОНД САНХҮҮЖИХ	ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
23.6	136	2.7	35
ИХ НАЯД ТӨГРӨГ	ТӨСӨЛ	ИХ НАЯД ТӨГРӨГ	ХУВЬ

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



Улсын хэмжээнд нийт **107 барилга, байгууламж** ашиглалтад орсон ба үүний 67 нь дэд бүтцийн салбарт, 40 нь нийгмийн салбарт багтаж байна.



Гадаад зээл, тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээг гүйцэтгэх нийт **1,508 ААН**, хувь хүнтэй гэрээ байгуулан ажилласан байна.



Зээл, тусламжийн 2024 онд **ашиглалт нийт 2.4 их наяд төгрөг** ба үүнд зээл 2 их наяд төгрөг, тусламж 435 тэрбум төгрөг байна.



Энэ хүрээнд **20.0+** мянган хүнийг ажлын байраар ханган ажиллаж, хөдөлмөр эрхлэлт, өсөлтийг дэмжин ажиллалаа.

Нийт гадаад зээл, тусламжийн ашиглалт 2024 онд 90 хувийн гүйцэтгэлтэй, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайд, Зам, тээврийн сайд нарын хэрэгжүүлж буй төслүүдийн зээл, тусламжийн ашиглалт 95-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

/Тэрбум төгрөг/

Хүснэгт 22. Гадаад зээл, тусламжийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчдаар:

ТЕЗ	ТӨСӨЛ	САНХҮҮЖИХ ДҮН	ОЛГОСОН	ХУВЬ	ҮЛДЭГДЭЛ
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	8	628.6	625.8	99.6%	2.8
Хууль зүй, дотоод хэргийн сайд	4	38.7	38.4	99.2%	0.3
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	1	192.5	190.9	99.1%	1.7
Монгол Улсын Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/	4	92.8	91.5	98.6%	1.3
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	3	11.2	11.0	98.5%	0.2
Зам, тээврийн сайд	10	209.8	199.9	95.3%	9.9
Монгол Улсын Сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	5	16.8	15.9	94.5%	0.9
Эрүүл мэндийн сайд	17	222.5	205.7	92.5%	16.7
Боловсролын сайд	9	87.6	80.8	92.2%	6.8
Нийслэлийн Засаг дарга	25	341.5	308.3	90.3%	33.2
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4	29.8	26.8	89.9%	3.0
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн	10	91.7	81.8	89.2%	9.9

сайд					
Сангийн сайд	7	384.1	336.1	87.5%	48.0
Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	5	4.7	3.8	80.0%	0.9
Эрчим хүчний сайд	18	389.4	274.5	70.5%	114.9
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	2	2.1	1.4	64.8%	0.7
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	2	22.5	13.3	59.1%	9.2
Орхон аймгийн Засаг дарга	2	0.7	0.2	25.7%	0.5
ЗЭЭЛ	100	2,209.0	2,068.1	93.6%	140.9
ТУСЛАМЖ	36	558.0	437.9	78.5%	120.1
НИЙТ	136	2,767.0	2,506.0	90.6%	261.0

2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


1. Төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны гүйцэтгэл

1.1 Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,320 төсөл, арга хэмжээнд 3,853.6 тэрбум төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,319 төсөл, арга хэмжээнд 3,828.6 тэрбум төгрөг, “Барих- шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 25.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 712 төсөл, арга хэмжээнд 1,687.0 тэрбум төгрөг, өмнөх онуудаас шилжин хэрэгжиж байгаа 607 төсөл, арга хэмжээнд 1,406.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, гүйцэтгэл 80.3%-ийн биелэлттэй гарлаа. Мөн эдгээр төслүүдийг санхүүжүүлснээр 1,531 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, 36.0 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, 3,093.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжлээ.

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ - 2024



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



Улсын хэмжээнд нийт **338 барилга, байгууламж** ашиглалтад орсон ба үүнээс 218 нь дэд бүтцийн салбарт, 120 нь нийгмийн салбарт багтаж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэх нийт **1,531 ААН**-тэй гэрээ байгуулан ажилласан байна.



Их засварын **48 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж, гүйцэтгэл **93.5** хувьтай гарсан бол тоног, төхөөрөмжийн шинэчлэлтэд чиглэсэн **235 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж гүйцэтгэл **89.9** хувьтай гарлаа.




Энэ хүрээнд **36.0+** мянган хүнийг ажлын байраар ханган ажиллаж, хөдөлмөр эрхлэлт, өсөлтийг дэмжин ажиллалаа.

1.2 ДНБ ба төсвийн хөрөнгө оруулалт

ДНБ-ний 1 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг дэд бүтцэд зарцуулахад ДНБ-ний өсөлт 1 функтээр нэмэгддэг байна. Дэд бүтэц сайжирснаар улсын хөгжил, өрсөлдөх чадвар нэмэгдэх, нийгмийн амьдралын чанар сайжрах зэрэг олон ач холбогдолтой. Хөгжиж буй улс орнуудын хувьд дунджаар ДНБ-ний 6.6 хувийг дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулах шаардлагатай байдаг бол Монгол Улсын хувьд дунджаар **ДНБ-ний 3.9%-ийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байна.**


Зураг 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг/



1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, 2020-2024 он

2020-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт давхардсан тоогоор **6,301 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлэхээр 11,856.1 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас **10,483.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож**, гүйцэтгэл дунджаар 89.3 хувьтай байна. 2023 оны хувьд эхлүүлсэн төслүүдийг дуусгах зорилт тавьж, шинэ төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгаагүй бөгөөд гүйцэтгэл хамгийн өндөр буюу 96.4 хувьд хүрсэн бол **2024 онд гүйцэтгэл 80.3 хувьтай байна.**

Зураг 16. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, 2020-2024 он тэрбум төгрөг/



1.4 Санхүүжилтийн зохицуулалтын арга хэмжээ

Төсвийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 4.8.37 дахь заалтад тус тус үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн саналын дагуу гүйцэтгэл, хэрэгжилт сайн 118 төсөл, арга хэмжээнд 127.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн зохицуулалт хийж, 2024 онд багтаан олголоо. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын хүрээнд гэрээ байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн 462 төсөл, арга хэмжээний 691.6 тэрбум төгрөгийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 2025 оны 08 сарын 31-ны өдрийн дотор гүйцэтгэлээр олгох санхүүгийн арга хэрэгслийг авч хэрэгжүүлсэн. Ингэснээр төслүүд хугацаандаа ашиглалтад орох, нэмэлт санхүүжилт үүсэхээс сэргийлэх, дараа онуудын төсвийн ачааллыг бууруулах зэрэг ач холбогдолтой.

1.5 Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл(ТЕЗ-аар)

2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 11,867.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,320 төсөл, арга хэмжээ батлагдаж, оны эцсийн байдлаар 80.3 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1319 төсөл, арга хэмжээнд 3,093.5 тэрбум төгрөг санхүүжилт олгогдож, гүйцэтгэл 80.8 хувь, “Барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 25.0 тэрбум төгрөг батлагдаж, гүйцэтгэл гараагүй байна.

Хүснэгт 22. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл төсвийн ерөнхийлөн захирагчдаар:


ТЕЗ	Төсөл	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Олгосон	Хувь	Үлдэгдэл
Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	2	5.5	5.5	5.5	99.9%	0.0
Батлан хамгаалахын сайд	9	69.8	55.8	55.6	99.7%	0.1
Гадаад харилцааны сайд	2	13.7	13.7	13.4	97.7%	0.3
Монгол Улсын Шадар сайд	11	50.8	29.7	29.2	98.4%	0.5
Улсын ерөнхий прокурор	6	46.0	11.3	11.0	97.3%	0.3
Монгол Улсын Их Хурлын дарга	2	22.1	22.1	21.4	96.9%	0.7
Хууль зүй, дотоод хэргийн сайд	39	195.1	127.2	121.2	95.3%	6.0
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	2	11.5	11.5	11.0	95.2%	0.6
Сангийн сайд	8	733.3	293.6	277.1	94.4%	16.5
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	0.9	0.9	0.8	92.2%	0.1
Авлигатай тэмцэх газрын дарга	1	2.7	2.7	2.4	92.1%	0.2
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	6	263.0	127.5	117.2	91.9%	10.3
Эрчим хүчний сайд	56	627.1	226.0	203.3	90.0%	22.7
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	15	35.5	20.5	18.4	89.5%	2.1
Монгол Улсын Ерөнхий сайд	1	1.2	1.2	1.1	88.3%	0.1
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	81	232.3	121.7	106.3	87.4%	15.3
Монгол Улсын Ерөнхий аудитор	1	0.9	0.9	0.8	86.7%	0.1
Зам, тээврийн сайд	125	2,881.6	737.1	635.5	86.2%	101.7
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	140	1,146.8	413.8	349.8	84.5%	64.0
Боловсролын сайд	440	2,221.9	723.1	546.9	75.6%	176.2
Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	4	422.9	116.2	87.9	75.7%	28.3
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	141	863.1	244.7	180.4	73.7%	64.3

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	3	90.9	20.0	14.7	73.6%	5.3
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	43	134.6	48.8	35.5	72.7%	13.3
Эрүүл мэндийн сайд	128	691.1	282.6	199.2	70.5%	83.5
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	11	32.0	16.4	5.3	32.2%	11.1
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	41	783.5	154.2	42.7	27.7%	111.5
УЛСЫН ТӨСВИЙН ДҮН	1319	11,579.7	3,828.6	3,093.5	80.8%	735.1
КОНЦЕССЫН ДҮН	1	287.4	25.0	-	0.0%	25.0
НИЙТ	1320	11,867.1	3,853.6	3,093.5	80.3%	760.1

1.6 Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (бүсээр)

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “**МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**” батлагдсан бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төслүүдийг бүс нутгаар нь харвал Хангайн бүсийн гүйцэтгэл хамгийн өндөр буюу 89 хувь, Хойд бүсийн гүйцэтгэл хамгийн бага буюу 74 хувьтай тус тус гарсан бөгөөд улсын хэмжээнд гүйцэтгэл дунджаар 81.5 хувьтай байна.

Зураг 17. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, бүсээр /тэрбум төгрөг/



1.7 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Уг хуулийн 19.1-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой, үр ашигтай төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр 2024 онд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах, айл, өрхийн ариун цэврийн байгууламж, нийтийн эзэмшлийн байр, орон сууцны шинэчлэл зэрэг хуулиар хориглосон төслүүдийг шинээр хэрэгжүүлээгүй болно. Мөн хуулийн 13.1.3-т заасан “худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтын хүрээнд нийт 58.4 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болсон ба үүний 21.2 тэрбум төгрөг нь тендерийн хэмнэлт, 37.2 тэрбум төгрөг нь гүйцэтгэлийн хэмнэлт байна. Түүнчлэн хуулийн 13 дугаар зүйлийн зарим заалтууд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх бөгөөд 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй тохиолдолд санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох зохицуулалт хэрэгжиж, үүний хүрээнд бэлтгэл хангагдаагүй, хэрэгцээ шаардлага бүрэн тодорхойлогдоогүй төслүүдийг зогсоох, үр ашигтай төслүүдийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглүүлээ.

2.1 Боловсролын салбар

2024 онд боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт **454 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж, **544 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, энэ хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн стандартыг сайжруулах, 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиудын ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүллээ. Үүний үр дүнд 2024 онд нийтдээ **26 сургууль ашиглалтад орсон бөгөөд тэдгээрээс 7 сургууль нь 3 ээлжийн ачааллыг бууруулж**, улсын хэмжээнд ээлжийн коэффициент **2023 оноос 0.03 пунктээр буурч 1.27 боллоо.**



Ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолоор “Эрдэнэт” ТӨҮГ-аар 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, Засгийн газрын 2021 оны 127 дугаар

тогтоолын дагуу төсөл, арга хэмжээг эхлүүлэн 4 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2024 онд энэ төслийн хүрээнд **35.5 тэрбум төгрөгийн** санхүүжилтийг олгож, 512 боловсролын байгууллага стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон байна.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалт

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч, хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд нийт 14.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ясли, 3 цэцэрлэгийн барилгын ажлыг хэрэгжүүлж, үүнээс Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 1 цэцэрлэгийн барилга ашиглалтад орлоо.

Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн санхүүжилт

2024 онд улсын хэмжээнд нийт 44 тоног, төхөөрөмжийн төсөл хэрэгжиж, 59.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо. Үүнээс үдийн хоол үйлдвэрлэлийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр гал тогооны тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалтыг жил бүр тусгаж, 2024 онд 5.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

2.2 Эрүүл мэндийн салбар

Эрүүл мэндийн салбарт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт **691.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 128 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж, 199.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олголоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ангиллаар нь харвал барилга, байгууламжийн ангиллын нийт 27 эмнэлэг, 51 эрүүл мэндийн төв, 5 судалгаа болон лабораторийн барилгын ажил хэрэгжсэн ба 3 шугам сүлжээний ажил хийгдсэн байна. Мөн их засварын ангиллын 36.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмжийн ангиллын 58.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн.



2024 онд орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 43 эрүүл мэндийн төв барих, өргөтгөх ажил хэрэгжиж, сум, суурин газрын иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг ойртуулахад чиглэлээ.

Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 3.3.2.-т “Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу дараах бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлж байна:

- *Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ - 140 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан ба одоогоор барилгын ажил 10 хувьтай байна.*
- *Хавдар судлалын үндэсний төвийн салбар II /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ - Зураг төсөл боловсруулах ажлын гэрээ цуцлагдсан ба худалдан авах ажиллагааг дахин зарлаж, гэрээ байгуулах шатанд явж байна.*
- *Халдварт өвчин судлалын үндэсний төв-2-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ - 13.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2024 онд батлагдсан ба ажлын гүйцэтгэл 25 хувьтай байна.*

2.3 Зам, тээврийн салбар

Зам, тээврийн сайдын хэрэгжүүлэх барилга байгууламж, их засвар, зөвлөх үйлчилгээний **2,881.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 125 багц төсөл, арга хэмжээнд** 737.1 тэрбум төгрөгийг энэ онд зарцуулахаар баталснаас 635.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, санхүүжилт 86.2 хувийн биелэлттэй байна.



Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 4.3.1-д заасан “Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилтын хүрээнд 2024 оны улсын төсөвт нийт 777.6 км-ын урт бүхий авто замын бүтээн байгуулалтын ажил тусгагдсан.

Тухайлбал Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох босоо тэнхлэгийн авто замыг барих ажлын хүрээнд 123 км бүхий авто зам 2024 онд ашиглалтад орлоо. Мөн стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон авто замын бүтээн байгуулалтыг эхлүүлсэн:

- Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн авто зам, 124.5км /26.7%/
- Чойбалсан хотоос Ульхан боомт чиглэлийн авто зам, 50км /26.7%/
- Чингис – Норовлин - Дадал чиглэлийн авто зам, 234км /76%/
- Хужирт - Төвхөн хийд - Улаан цутгалан чиглэлийн авто зам, 90.1км /48%/
- Өлгий - Улаанхус сум - Алтай таван богд уул чиглэлийн авто зам, 23.13км /17.7%/

2.4 Хот байгуулалт, барилгын салбар

Хот байгуулалт, барилгын салбарт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар **1,146.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 140 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлэхээр тусгасан.

Залуус-1 төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил

Тус төслийн хүрээнд 33.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий арга хэмжээг хэрэгжүүлж, 2024 онд санхүүжилтийн гүйцэтгэл 100% буюу 12.6 тэрбум төгрөгийг олгоод байна. Үүнд 300м урт бүхий дулаан хангамжийн сүлжээний өргөтгөл, 1750м шугам хоолойн угсралт зэрэг ажил хийгдсэн ба энэхүү төсөл нь 2025 онд бүрэн хэрэгжиж дуусна.

Улаанбаатар хотын гэр хорооллыг дэд бүтцээр хангахад:

2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын инженерийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр инженерийн шугам сүлжээг шинэчлэх, гудамж, талбайн тохижилтыг хийх зэрэг нийт 28.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд аймаг, сумдын дэд бүтцийн хангамжийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийгдэж, нийт 164 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд үерийн далан, хамгаалалтын байгууламж, сумын төвийн шинэчлэл хөтөлбөр, нийтийн халуун усны барилга, сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл зэрэг төсөл, арга хэмжээ багтаж байна.

2.5 Эрчим хүчний салбар

Эрчим хүчний салбарт 2024 онд нийт **627.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж, 203.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 2.3.2-т “Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.” гэж тусгасны дагуу дараах арга хэмжээ хэрэгжлээ.

10 аймгийн төвд баригдах ДЦС-ын дэд бүтцийг бүрдүүлэх төсөл

Нийт 10 аймгийн төвд баригдаж байгаа дулааны цахилгаан станцын цахилгаан хангамж, дэд бүтцийг бүрдүүлэх төсөл, арга хэмжээг 2024 оны төсөвт нийт 51.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр тусгаж, 22.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо. Эдгээрээс 8 төсөл нь 2025 онд, 2 төсөл нь 2026 онд хэрэгжиж дуусах төлөвтэй байна.

Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төсөл

“Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн ус хангамж, цахилгаан хангамжийн дэд бүтцээр хангах хүрээнд нийт 138.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 дэд ажил хэрэгжиж, 45.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.



2.6 Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбар

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт 2024 онд нийт **863.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 141 төсөл, арга хэмжээг** хэрэгжүүлж, 180.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Соёл урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн ажлууд

Нийт 16 аймагт 161.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 соёлын төвийн барилга барих ажлыг хэрэгжүүлж, үүнээс 2024 онд 2,390 суудал бүхий 9 соёлын төв ашиглалтад орлоо. Мөн 322.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 музей, театрын барилга, 48.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 номын сан барих төсөл, арга хэмжээ хэрэгжиж, үүнээс 800 суудлын хүчин чадал бүхий 3 номын сан ашиглалтад орлоо.

Биеийн тамир, спортыг дэмжихэд чиглэсэн нийт 266.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 39 спорт цогцолбор, заалны барилгын ажлыг хэрэгжүүлж, үүнд нийслэлийн 3 дүүрэгт усан бассейн бүхий спорт цогцолборыг барих ажил багтаж байна.

Ашиглалтад орсон томоохон бүтээн байгуулалтууд

- ✓ Үндэсний номын сан өөрийн анхны салбар номын сангийн үйл ажиллагаа явуулах барилгыг ашиглалтад хүлээн авч, 16 танхим, 530 хүний хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.
- ✓ 2011 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн Дархан-Уул аймгийн 2,200 хүний суудал бүхий Спорт цогцолбор бүрэн ашиглалтад орлоо.
- ✓ Архангай аймгийн Эрдэнэбулган сумд 1,000 хүний суудал бүхий том заал, гадна бэлтгэлийн 6 заал, пара болон хөнгөн атлетикийн зориулалттай 2 заалнаас бүрдэж байгаа “ARA arena” спорт ордон ашиглалтад орлоо.
- ✓ Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 700 суудлын хүчин чадалтай спорт заал, 4 зам усан бассейн бүхий спорт цогцолбор ашиглалтад орлоо.

2. “Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд

Сангийн яам, Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал” төслийн хүрээнд **Хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/**-ийг үе шаттайгаар хөгжүүлэн, төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч бүхий л этгээдийг хамруулан, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг сайжруулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн хамрах хүрээ нэмэгдэж байна.

- ✓ “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрнуудын “Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн үйл ажиллагааг 100% цахим системд шилжүүллээ.
- ✓ Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг 100% цахим болгож дууссан бөгөөд хүний үйл ажиллагааг хөнгөвчлөх, төрийн бусад системүүдтэй холбох нэмэлт сайжруулалт, шинэ хөгжүүлэлтийг хийсээр байна.

- ✓ Гадаад зээл, тусламжийн мэдээллийн систем (ODAMIS)-ийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-тэй үе шаттайгаар нэгтгэх ажлыг 2024 онд хийж, гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн нэгжийн ажилтнуудад мэдээллийг шинэчлэн оруулах талаар сургалт, зааварчилгааг өгсөн.
- ✓ 2024 онд Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар баталсан "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал"-ыг цахим системд хэрэгжүүлэх боломжтой боллоо.
- ✓ Техник, технологийн хяналт хийж буй "Захиалагчийн хяналт"-ын үйл ажиллагааг 100% цахим болголоо.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг цахим системээр хэрэгжүүлэх, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, ач холбогдлын шинжилгээг хэрхэн хийх талаар "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим шинэчлэл" цахим сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04- дугаар сарын 19-ний өдрүүдэд яамд, агентлаг, захиалагчийн техник хяналтын байгууллагууд болон 21 аймаг, 330 сумдын хөрөнгө оруулалт хариуцсан 720 гаруй албан хаагч нарыг хамруулж зохион байгуулсан бөгөөд нийт оролцогчдод "Батламж"-ийг олголоо. Мөн Дархан-Уул аймагт 2024 оны 5 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд "Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын удирдлагын системийн шинэчлэл" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн 160 гаруй албан хаагчид оролцсон байна.

"Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем - PIMIS"-ийн үйл ажиллагааны талаар төсвийн хөрөнгө оруулалтын аливаа үйл ажиллагаанд оролцогч албан хаагчдыг мэргэшүүлэхэд чиглэсэн 9 хэсэг бүхий гарын авлагыг боловсрууллаа.

3. 2024 оны үр дүн

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт **1,320 төсөл, арга хэмжээнд** зориулан 3.8 их наяд төгрөг батлагдсан бөгөөд үүнээс **3.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.**

Уг санхүүжилтийн хүрээнд нийтдээ 1.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 430 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, тэдгээрийн дотроос 1.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий **338 барилга, байгууламж ашиглалтад орсон** нь 2021 онтой харьцуулахад 46 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2024 онд олон жил удааширсан томоохон төслүүд амжилттай дуусаж, бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийг найдвартай дулаан, цахилгаан, ундны усаар хангах зэрэг чухал ач холбогдолтой бүтээн байгуулалтууд ашиглалтад орлоо.



Хүснэгт 23. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангилалаар /тэрбум төгрөг/

Ангилал	Төсөвт өртөг	Төслийн тоо
I. Барилга байгууламж	1,511.5	338
II. Их засвар	87.3	129
III. Тоног төхөөрөмж	299.0	173
IV. ТЭЗҮ	4.6	13
НИЙТ	1,902.4	653

Хүснэгт 24. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төрлөөр /тэрбум төгрөг/

Төрөл	Төслийн тоо	Төсөвт өртөг	Хүчин чадал	Хүчин чадлын нэгж
Дотуур байр	11	30.2	1,200	ор
Зам, гүүр	26	245.8	195	км
Инженерийн дэд бүтэц	32	158.8	-	
Соёлын төв, музей, театр	12	71.6	3,730	суудал
Спорт заал, цогцолбор, ордон	15	83.0	3,150	суудал
Сургууль	26	207.9	12,820	суудал
Цахилгаан, дулаан хангамж	76	313.4	-	
Цэцэрлэг	32	105.4	4,395	суудал
Эмнэлэг	24	130.5	1,913	ор
Бусад	84	164.9	-	
НИЙТ	338	1,511.5		

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2024 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.2-т “Засгийн газрын нөөц сан нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2024 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг 100 хувь төсвөөс санхүүжихээр тусгасан.

Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 25. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Дүн
2024 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө	128.5
Засгийн газрын тогтоолоор нийт санхүүжүүлсэн дүн	128.5
Үүнээс: 2020-2023 оны тогтоолын дүн	20.8
2024 оны тогтоолын дүн	107.7

Засгийн газрын нөөц сан 2024 онд 128.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 2024 онд Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр Засгийн газрын 51 тогтоолоор 128.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5-д заасан арга хэмжээний хүрээнд 2024 онд Засгийн газрын нөөц сангаас гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан осол гарсан үед хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах зардалд 62.0 тэрбум төгрөг, олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд 5.1 тэрбум төгрөг, төсвийн жилийн дундуур баталсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд 61.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 54.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.9, 24 дүгээр зүйлд заасны дагуу Ирээдүйн өв сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргалаа.

Баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангаас бүрдэнэ. 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,288.5 тэрбум төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 1,341.9 тэрбум төгрөг төвлөрч, гүйцэтгэл 104.1 хувьтай байна.

Засгийн газрын 2024 оны 179 дүгээр тогтоолд Хуримтлалын санд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор Монголбанктай гэрээ байгуулж ажиллахыг тусгасны дагуу “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г Монголбанктай байгуулж 495.6 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн.

Тайлант оны төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 26. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	1,288.5	1,341.9	53.4	104.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	789.0	841.3	52.3	106.6
Ноогдол ашгийн орлого	499.5	495.7	-3.8	99.2
Бусад орлого		4.9	4.9	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,288.5	1,341.9	53.4	104.1
НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,124.6		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,979.4		

4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 54.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.9, 24 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос хуваарилалт хийсэн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 144.4 тэрбум, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 296.7 тэрбум төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэв.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор төсөв тусгагдаагүй тул тус сангаас зардал гараагүй байна.

Хүснэгт 27. Тогтворжуулалтын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	478.6	443.9	34.7	92.8
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	147.1	144.4	2.8	98.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	331.4	296.7	34.8	89.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	478.6	443.9	34.7	92.8
Улсын төсвийн шилжүүлэг	-	-	-	
НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-	-	

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2024 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 1,964.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,921.7 тэрбум төгрөг төвлөрч, 97.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Нийгмийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн даатгалын санд 812.6 тэрбум төгрөг, Төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 324.1 тэрбум төгрөг, Төр хариуцах ТҮ-ний санхүүжилт 746.8 тэрбум төгрөг, Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 34.2 тэрбум төгрөг, торгуул, төлбөрийн орлого 3.9 тэрбум төгрөгийн орлого тус тус төвлөрсөн байна.

Хүснэгт 28. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,964.7	1,921.7	97.8	-43.0
Нийгмийн даатгалын орлого	1,964.7	1,921.7	97.8	-43.0
ЭМД-ын хураамжийн шимтгэл	1,964.7	1,921.7	97.8	-43.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,848.2	1,926.9	104.2	78.7
НИЙТ ЗАРЛАГА	1,933.2	1,931.3	100.0	-1.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,933.2	1,931.3	100.0	-1.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68.0	67.8	99.7	-1.7
ТАТААС	137.3	137.3	100.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,727.9	1,726.2	100.0	-1.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-85.0	-4.4	5.1	-80.6
Эргэж төлөгдөх зээл	-85.0	-4.4	5.1	-80.6
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-85.0	-5.2		-80.6
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-85.0	-5.2		-79.8

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1,933.2 тэрбум төгрөгөөр баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,931.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд 1,268.5 тэрбум төгрөгийг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардалд 425.1 тэрбум төгрөгийг, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээнд 31.8 тэрбум төгрөгийг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.3 тэрбум төгрөгийг тус тус Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна.

6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2024 онд 5,893.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 5,609.7 тэрбум төгрөг төвлөрч, 95.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 4,434.7 тэрбум төгрөг төвлөрч, 94.0 хувийн биелэлттэй, улсын төсвөөс олгох татаас 1,175.0 тэрбум төгрөгт хүрч, 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 29. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,893.3	5,609.7	95.2	-283.6
Татварын орлого	4,718.3	4,434.7	94.0	-283.6
Нийгмийн даатгалын орлого	4,718.3	4,434.7	94.0	-283.6
Татварын бус орлого	1,175.0	1,175.0	100.0	0.0
Хандив тусламж /дотоод/	1,175.0	1,175.0	100.0	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,121.2	5,104.7	99.7	-16.5
НИЙТ ЗАРЛАГА	5,188.4	5,107.2	98.4	-81.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1.1	0.8	75.3	-0.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,187.3	5,106.4	98.4	-80.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-67.2	-2.5	3.7	64.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	772.1	505.0	65.4	-267.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-772.1	-505.0	65.4	267.1
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-772.1	-505.0	65.4	267.1
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	5,893.3	5,609.7	95.2	-283.6

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2024 онд 5,104.7 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 99.7 хувьтай тэнцэж байна. Нийгмийн даатгалын сан нь 2024 онд 505.0 тэрбум төгрөгийн ашигтай тайлагнагдаж байна.

7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн орлогын 79.4 хувь татварын орлогоос, 20.6 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 46.5 хувь буюу 2,630.4 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 78.9 тэрбум төгрөгийг олгосон байна. Татварын бус орлогын 40.8 хувь буюу 599.9 тэрбум төгрөгийг нийтлэг татварын бус орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг 32.9 хувь буюу 483.8 тэрбум төгрөг, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг 25.0 хувь буюу 368.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 30. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,483.9	7,121.8	-362.1
Татварын орлого	5,955.4	5,652.4	-303.0
Орлогын албан татвар	4,839.3	4,663.0	-176.4
Хөрөнгийн албан татвар	455.2	459.5	4.2
Бусад татвар, төлбөр, хураамж	660.9	530.0	-130.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	161.2	134.0	-27.2
Газрын төлбөр	365.6	243.6	-121.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	100.7	121.6	20.8
Бусад татвар	33.3	30.7	-2.6
Татварын бус орлого	1,528.5	1,469.4	-59.1
Нийтлэг татварын бус орлого	621.2	600.0	-21.2
Хөрөнгийн орлого	16.1	6.3	-9.8
Тусламжийн орлого	19.7	11.2	-8.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	871.5	851.9	-19.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,239.7	7,258.6	-1,981.2
УРСГАЛ ЗАРДАЛ	4,801.2	4,244.6	-556.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,569.8	2,251.2	-318.6
ХҮҮ	72.5	70.0	-2.4
ТАТААС	355.9	353.4	-2.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,803.0	1,570.0	-232.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,279.6	2,888.7	-1,390.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	159.0	125.3	-33.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,755.8	-136.8	1,619.0
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,755.8	136.8	-1,619.0

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 58.5 хувь буюу 4,244.6 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 695.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 2,888.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1,390.9 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 368.0 тэрбум төгрөгийн, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс 483.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 1,415.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Дорнод аймаг 2.6 тэрбум төгрөг, Дархан-Уул аймаг 1.3 тэрбум төгрөг, Улаанбаатар 19.6 тэрбум төгрөг, Орхон аймаг 137.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн бол Дорноговь аймаг, Өмнөговь аймаг, Сэлэнгэ аймаг нийт 179.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлжээ. Дорноговь аймгийн дуудлага худалдааны орлого 86%, ААНОАТ-ын орлого 39.5%-иар буюу нийт 37.7 тэрбум төгрөгөөр тасарсны улмаас улсын төсөвт орлого дутуу төвлөрүүлсэн бол Өмнөговь, Сэлэнгэ аймгийн хувьд ААНОАТ-ын орлого тасарсан шалтгааны улмаас улсын төсөвт орлого дутуу төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлээр нийт 7,121.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөсөн дүнгээс 4.8 хувь буюу 362.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Харин нийт зарлага 7,258.6 тэрбум төгрөгт хүрснээр төлөвлөсөн дүнгээс 21.4 хувь буюу 1,981.2 тэрбум төгрөгөөр дутуу зарлагын гүйцэтгэл гарсан байна.

8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 30.8 их наяд төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 43.7 хувьтай тэнцэж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөг, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 41.8 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 31. Засгийн газрын өр, 2019-2024 он /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2019	2020	2021	2022	2023	2024
1. Засгийн газрын дотоод өр	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1	400.5
1.1. Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1	400.5
2. Засгийн газрын гадаад өр	20,728.1	24,851.4	24,693.3	29,641.6	30,274.6	30,247.8
2.1. Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7	8,655.0
2.2. Зээл	12,800.9	16,497.4	16,517.7	20,281.8	20,902.9	21,641.6
3. Бусад өр төлбөр	2,072.1	1,910.6	1,567.6	1,287.7	264.8	2,702.7
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	1,076.3	1,060.4	876.5	811.8	29.5	178.0
3.2. Орон нутгийн өр	-	-	17.2	12.3	4.5	2,524.7
3.2.1 Дотоод өр			17.2	12.3	4.5	799.9
3.2.2 Гадаад өр						1,724.9
3.3. Концесс ("барих-шилжүүлэх")*	995.7	850.2	673.9	463.5	230.9	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (1+2+3)	24,199.7	27,898.6	26,918.1	31,964.8	30,773.5	33,399.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	20,525.6	23,024.3	21,837.3	27,690.6	26,582.9	
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**	75.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	70.0% (ӨҮЦ)	65.0% (ӨҮЦ)	60.0% (Нэрлэсэн)
Засгийн газрын өр / ДНБ	64.9%	75.5%	62.6%	60.5%	43.7%	41.8%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	55.1%	62.3%	50.8%	52.4%	37.7%	-

* Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дэх хэсэг хүчингүй болсон.

** УИХ-аас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг байсныг нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл болгож өөрчилсөн.

Засгийн газрын өрийн багцын 95.9 хувийг Засгийн газрын болон орон нутгийн гадаад үнэт цаас, зээл, 3.6 хувийг Засгийн газрын болон орон нутгийн дотоод үнэт цаас, 0.5 хувийг Засгийн газрын өрийн баталгаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өрийн зохицуулалтаас бусад Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 2,714.9 тэрбум төгрөгийг төлснөөс үндсэн төлбөрт 1,548.9 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт нийт 1,165.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 32. Засгийн газрын 2024 оны өрийн үйлчилгээ /тэрбум төгрөг/

№	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	2024 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан үндсэн төлбөр	1,940.4	1,548.9
1.1	Гадаад үнэт цаас	570.0	178.5
1.2	Гадаад зээл	1,232.9	1,232.9
1.3	Дотоод үнэт цаас	137.5	137.5
2	Гадаад үнэт цаасны өрийн зохицуулалт	Өрийн зохицуулалт	731.4


2.1	Номад бонд	Өрийн зохицуулалт/ Буцаан худалдан авалт	40.8
2.2	Сенчири-1 бонд	Өрийн зохицуулалт/ Буцаан худалдан авалт	296.1
2.3	Сенчири-3 бонд	Өрийн зохицуулалт	394.4
3	Хүүгийн төлбөр	1,173.6	1,165.9
3.1	Гадаад зээл	607.0	599.4
3.2	Гадаад үнэт цаас	559.1	559.1
3.3	Дотоод үнэт цаас	7.5	7.5
4	Өрийн зохицуулалтаас бусад нийт төлбөр	3,114.0	2,714.9

Засгийн газрын өрийн зохицуулалтын хүрээнд өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн дагуу гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийсний үндсэн дээр “Номад” бондоос нийт 12.0 сая ам доллар, “Сенчири-1” бондоос нийт 86.9 сая ам доллартой тэнцэх хэмжээний үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авсан бөгөөд 2024 оны 03 дугаар сард төлсөн Хуралдай бондын төлбөрийн 116.9 сая ам.доллартой тэнцэх хэмжээний төлбөрийг 2023 оны 12 дугаар сард гаргасан “Сенчири-3” бондын үлдэгдлээс төлж барагдуулсан нь нийт 731.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 234.1 тэрбум төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 400.5 тэрбум төгрөг болж, 166.4 тэрбум төгрөгөөр өсөөд байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл өссөн нь Засгийн газраас 2024 онд Нийгмийн даатгалын санд хаалттай хэлбэрээр 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсантай холбоотой байна. Энэхүү үнэт цаасыг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу арилжаалсан.

Зураг 18. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл / тэрбум төгрөг/



Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 303.4 тэрбум төгрөг буюу 75.8 хувийг 2024 онд гаргасан мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 97.1 тэрбум төгрөг буюу 24.2 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна. Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 137.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 7.5 тэрбум төгрөг, нийт 145.0 тэрбум төгрөгийг төлсөн.

8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 9,371.7 тэрбум төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 8,655.0 тэрбум төгрөг болон буурсан байна.

Хүснэгт 33. Засгийн газрын гадаад үнэт цаасны 2024 оны үлдэгдэл

№	Гадаад үнэт цаас	Гаргасан дүн	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Үлдэгдэл 2024.12.31	
						Сая ам.доллар	тэрбум төгрөг
1	Номад	600 сая ам.доллар	2020.10.07	5.125%	5.5 жил	572.7	1,958.7
2	Сенчири-1 2027`	500 сая ам.доллар	2021.07.07	3.500%	6 жил	420.1	1,436.8
3	Сенчири-1 2031`	500 сая ам.доллар	2021.07.07	4.450%	10 жил	510.7	1,746.7
4	Сенчири-2	650 сая ам.доллар	2023.01.19	8.650%	5 жил	675.1	2,309.2
5	Сенчири-3	350 сая ам.доллар	2023.12.05	7.875%	5.5 жил	351.9	1,203.6
НИЙТ						2,530.5	8,655.0

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт нийт 910.0 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үүнээс “Хуралдай” бондын үндсэн төлбөрт 573.0 тэрбум төгрөгийг, “Сенчири-1” бондын үндсэн төлбөрт 296.1 тэрбум төгрөгийг, “Номад” бондын үндсэн төлбөрт 40.8 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 559.1 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөнөөс “Сенчири-1” бондын хүүгийн төлбөрт 138.6 тэрбум төгрөг, “Сенчири-2” бондын хүүгийн төлбөрт 190.9 тэрбум төгрөг, “Хуралдай” бондын хүүгийн төлбөрт 25.1 тэрбум төгрөг, “Сенчири-3” бондын хүүгийн төлбөрт 104.2 тэрбум төгрөг, “Номад” бондын хүүгийн төлбөрт 100.2 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

8.3. ГАДААД ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2023 оны жилийн эцэст 20,902.9 тэрбум төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 21,641.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 64.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 34. Гадаад зээлийн үлдэгдэл /2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл тэрбум төгрөгөөр/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүү	Ханшийн зөрүү	Хувь
1	Төслийн зээл	14,690.5	2,070.6	717.8	15,607.7	103.7	(435.6)	72.7%
2	Хөтөлбөрийн зээл	6,212.4	341.8	515.2	5,872.5	57.7	(166.5)	27.3%
Нийт		20,902.9	2,412.3	1,232.9	21,480.2	161.4	(602.1)	100.0%

Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 80 төсөл, хөтөлбөрийг хүрээнд 2024 онд нийт 2,412.3 тэрбум төгрөгийг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 2,070.6 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 341.8 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байна.

Хэрэгжиж буй төслүүдийн томоохон ашиглалтуудаас дурдвал: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-д 190.9 тэрбум төгрөг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төсөлд 220.3 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрчим хүч ашиглах хуримтлуур” төслийн хүрээнд 159.4 тэрбум төгрөг, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар-Дархан чиглэлийн 2 эгнээ зам барих төслийн хүрээнд 109.5 тэрбум, Бүгд Найрамдах Солонгос Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл” төслийн хүрээнд 178.8 төгрөгийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж 2024 онд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 1,832.3 тэрбум төгрөгийг төлсөн. Үүнээс 1,232.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрт, 599.4 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн.

8.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 29.5 тэрбум төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 178.0 тэрбум төгрөг болж өссөн. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл өссөн шалтгаан нь 2024 оны 05 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд өрийн баталгаа гаргасантай холбоотой байна.

Хүснэгт 35. Засгийн газрын өрийн баталгааны 2024 оны үлдэгдэл

#	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	Баталгаа гаргасан огноо	2024.12.31		
					үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг	Сая ам.доллар
1	Монгол Улсын Хөгжлийн банк	Хятадын хөгжлийн банк	Юань	2024.04.01	362.0	178.0	52.0
НИЙТ						178.0	52.0

Тайлант хугацаанд “Эрдэнэс Монгол” ХХК 2031 онд төлөгдөх нөхцөлтэй зээлийн төлбөрийг хугацаанаас өмнө буюу 2024 оны 10 дугаар сард төлж барагдуулсан болно.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас олон улсын зах зээлд “Сэлбэ дэд төвийн орон сууцжуулалтын төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан 500 сая ам.долларын үнэт цаасанд 2024 оны 11 дүгээр сард Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу аймаг, нийслэлийн өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Засгийн газрын өрд тооцогддог тул тухайн үнэт цаасны үлдэгдлийг Засгийн газрын өрийн нэгтгэлд орон нутгийн өр хэсэгт тайлагнасан болно.

8.5. ОРОН НУТГИЙН ЗЭЭЛЛЭГ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажлын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад зориулж гаргаад байна. Ингэснээр орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,524.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 36. Орон нутгийн өр /2024.12.31/

№	Үнэт цаас гаргагч	Зориулалт	Гаргасан огноо	Эргэн төлөх огноо	Нэрлэсэн үлдэгдэл
					Тэрбум төгрөг
1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Зам засвар, арчилгаа	2024.06.25	2025.06.25	100.2
2		Зам засвар, арчилгаа	2024.06.25	2026.06.25	100.3
3		Бөөрөлжүүтийн ДЦС барих	2024.06.25	2027.06.25	300.8
4		Батарей хуримтлуурын станц барих	2024.12.26	2029.12.26	298.6
5		Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах	2024.11.29	2027.08.29	1,724.9
	НИЙТ				2,524.7

8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2023 он хүртэлх хугацаанд нийт 8.5 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласнаас 2.1 тэрбум ам.долларыг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,706.0 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 461.8 тэрбум төгрөгийг нэмж олгон, олгосон зээлийн эргэн төлөлтөд нийт 381.1 тэрбум төгрөгийн /үүнээс үндсэн төлбөрт 307.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 73.3 тэрбум төгрөг/ орлогыг төсөвт төвлөрүүлж 2024 оны жилийн эцсийн байдлаар дамжуулан зээлийн үлдэгдэл 3,776.9 тэрбум төгрөг байна.

Тайлант хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарснаас шалтгаалан ханшийн зөрүүгээр дамжуулан зээлийн үлдэгдэл 57.0 тэрбум төгрөгөөр буурсан.

Хүснэгт 37. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	1,956.2	215.1	159.3	(29.7)	1,982.4
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	1,380.1	246.6	143.7	(18.6)	1,464.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	369.7		4.7	(34.7)	330.2
НИЙТ	3,706.0	461.8	307.7	(83.0)	3,776.9

Хүснэгт 38. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл /салбараар/

№	Салбар	2018	2019	2020	2021	2022	2023	2024
1	Жижиг дунд үйлдвэрлэл	114	140	204	176.6	179.3	160.7	137.7
2	Зам, тээврийн салбар	379	466	513	580.1	655.6	631.9	551.8
3	Нийгмийн халамжийн салбар	21	26	11	10.8	11.7	2.7	12.2
4	ОСНААҮ-ий салбар	521	639	810	843.8	980.4	1,006.9	1,019.6
5	Санхүү, эдийн засгийн салбар	162	199	201	168.5	227.0	258.1	271.7
6	Хувийн хэвшлийн хуулийн этгээд	245	300	328	320.8	374.3	377.1	341.6
7	Уул уурхайн салбар	83	102	90	121.0	118.6	111.3	97.5
8	Харилцаа холбооны салбар	61	74	59	54.9	55.1	52.4	48.0
9	Хөдөө аж ахуйн салбар	212	261	264	310.6	324.9	308.8	294.8

10	Эрчим хүчний салбар	372	456	508	518.5	649.2	796.0	1,002.0
	НИЙТ	2,170	2,663	2,988	3,105.7	3,576.3	3,706.0	3,776.9

Эргэн төлөлтийн талаар:

Хүснэгт 39. Дамжуулан зээлийн гэрээний дагуу төлбөрөө 2024 онд бүрэн төлж дууссан зээлүүд

Дугаар	Донор	Эцсийн зээлдэгч	Валют	Гэрээ байгуулсан он	Гэрээний дүн
OL-CLA5-MON-1	Япон	Багануур ХК	JPY	2021	907,016,500.00
OL-5974MOG	ДБ	ХНХЯам	USD	2018	6,440,000.00
OL-CLA3-JBIC	Япон	ХААН банк	USD	2017	3,672,000.00
OL-1847MON-07	АХБ	Багануур Ус	MNT	2003	209,180,000.00
OL-3503MOG-01	ДБ	Алтай-Улиастайн ЭХС ТӨХК	MNT	2003	697,141,538.77
OL-4330MOG-S-18	ДБ	Ирээдүй инвест ББСБ	MNT	2020	163,208,069.00
OL-4330MOG-S-19	ДБ	Кредит Монгол ББСБ	MNT	2020	720,000,000.00

---oOo---